MINFO.

18 дахь жилдээ

МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,116.025... ҮСХ-ны өгөгдлийн мэдээгээр

2016.11.16. Лхагва. №204 (4574) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

УЛС ТӨР

ЭНЭ САРЫН 17-25-НЫ ӨДРҮҮДЭД -47 ХЭМ ХҮРЧ ХҮЙТРЭХ НЬ

II нүүрт

ДЭЛХИЙ

ОХУ-ЫН САЙД ҮЙЛДЭЛ ДЭЭРЭЭ БАРИВЧЛАГДЖЭЭ

IV нүүрт

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР

Дугаарын **60** мөр

“Аз жаргал”-ын биш аваар, ослын хот боллоо

Ж.ӨӨДЛӨН

Цас орсон өдрийн маргааш нь л зам, талбай бараг цас мөсгүй болчихдог байж дээ. Өөрөөр хэлбэл, өнгөрсөн жилүүдэд цас орж эхэлсэн даруйд л шөнийн цагаар ч хамаагүй цас хайлуулах бодисоо цацаж, иргэдийг өглөө ажил, хичээлдээ явах үед цас хэдийнэ хайлж, замын хөдөлгөөн хэвийн үргэлжилдэг байсансан. Байлаа гэсний учир “Аз жаргалтай хот”-ыг цогцлоогчид хотын эзэд болсон эхний цаснаар л өнгөрснөө дурссан нь энэ.

Учир нь их хотын зам талбай мөсөн гулгуур адил болж, энд тэндгүй унаж бэртсэн иргэд, мөргөлдөж, эвдэрсэн машинууд таарах боллоо. Тухайлбал, ГССҮТ-д өдөрт 300-400 хүн унаж бэртсэн гэх шалтгаантай оочерлох болсон гэнэ. Цас орсноос хойш хальтирч унасан, машины ослоор гэмтсэн тохиолдол бүр ч нэмэгдсэн гэдгийг Гэмтэл согог судлалын үндэсний төвийн статистик, тандалт судалгааны албанаас мэдээлж байгаа юм.

Үргэлжлэл нь III нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

10 ТЭРБУМЫН АШИГТАЙ АЖИЛЛАДАГ “МОНГОЛ ШУУДАН” КОМПАНИЙГ ХУВЬЧЛАХ ГЭЖ ЯАРАХЫН УЧИР ЮУН

Н.ПУНЦАГБОЛД

УИХ ямар ч байсан хуулийн хугацаандаа ирэх оныхоо төсвийг баталсан. Тэгэхдээ 9.1 хувийн алдагдалтай төсөв баталчихаад байгаа юм. Уг нь эхэндээ 9.9 хувийн алдагдалтай байсан ч бууруулж чадсан. Энэ нь орлогоо нэмэхээр тооцсонтой холбоотой юм. Тэр дундаа өмч хувьчлалын орлогыг 50 тэрбумаар нэмэгдүүлэхээр болсон. Ингэхдээ “Монгол шуудан” компанийг 20, “Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” компанийг 30 тэрбум төгрөгөөр хувьчлахаарболоодбайгаа юм. Үүнээс гадна Төрийн банк, “Оргил” рашаан сувилал, Хөрөнгийн бирж гээд хувьчлалд өртөх төрийн өмчийн компани, аж ахуйн нэгжүүд цөөнгүй бий.

Тэр дундаас хамгийн их анхаарал татаж байгаа нь “Монгол шуудан” компанийн хувьчлал. Энэ асуудал дээр УИХ-ын гишүүдээс ганц дуугарч, эсэргүүцсэн нь Т.Аюурсайхан гишүүн. Бусад нь бол нүдэн балай, чихэн дүлий суусаар, “Монгол шуудан”-г хувьчлахаар болчихлоо. Хувьчлах хувьчлахдаа ердөө л 20 тэрбумхан төгрөгөөр шүү дээ. Яаж үнэлэхээрээ ингэдэг юм, бүү мэд. Тэгэхэд Төрийн ордны зүүн талд байрладаг “Улаанбаатар таймс” сонины байр буюу хуучны Сүхбаатар хэвлэх үйлдвэрийн байрыг газартай нь хамт дуудлага худалдаагаар худалдаж, 24 тэрбум төгрөгийн үнэ хүргэсэн. Хотын төвд, А зэрэглэлд байрлалтай, 2698 м2 талбай бүхий эл газрыг Абдул Карим гэх араб гаралтай Монголын иргэн дуудлага худалдаагаар эзэмшихээр болсон ч татгалзаж, Абдулын дараах өндөр үнэ хэлсэн “Таван богд” группд эрх нь шилжсэн. Мэдээж газрынх нь байршлаас хамааралд үнэд хүрсэн гэдгийг үгүйсгэхгүй л дээ.

Үргэлжлэл нь III нүүрт

ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

Дэлхийд өрсөлдөхүйц МОНГОЛ УР ЧАДВАРТАНГ “ҮЙЛДВЭРЛЭДЭГ” коллеж



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Н.БАТЗАЯА

Сүүлийн хэдэн жилд манай улсад “дипломтой ажилгүйчүүд” гэх нэр томъёо дэлгэрч, бидний чихэнд аль хэдийнэ дасал болж, байх ёстой юм шиг л боддог болжээ. Жил бүр энэ эгнээнд элсэгчдийн тоо нэмэгдэж байгааг нуух юун. Өндөр төлбөртэй их, дээд сургуульд дөрвөн жил суралцсан хэдий ч ажлын байранд бүрэн зуучлагдаж чадалгүй лангуу-ны мухар сахиж аль эсвэл албан байгууллагын үйлчлэгч хийх болсон гэхэд үнэнээс хол зөрөхгүй.

Үргэлжлэл нь VI-VII нүүрт

ОНЦЛОХ МЭДЭЭ

АН-ынхан жирийн гишүүдээсээ айгаад Төрийн ордонд хуралдах уу

Ардчилсан намын Үндэсний зөвлөлдөх хорооны хурал өнөөдөр болох учиртай. Өмнө нь гурван ч удаа товлогдоод хойшилсон ҮЗХ-ны хурал энэ удаад хойшлохгүй юм байна. Харин АН-ынхан энэхүү хурлаа Төрийн ордонд хийхээр болсон сурагтай. Үүнийг нь жирийн гишүүд, дэмжигчдээсээ айж байгаагийн илрэл хэмээн гишүүд, дэмжигчид нь үзэж байгаа аж. Мөн АН үнэхээр шинэчлэл хийж чадах уу, эсвэл дарга нар, фракциуд нь нэг байр суурьт хүрэх үү гэдэг асуудлыг сөхөж тавьж байгаа бололтой. АН-ын ҮЗХ-ны энэ удаагийн хурлаар намын даргын асуудлыг ярихгүй, зөвхөн ирэх сарын эхээр болох Их хурлын бэлтгэл ажлыг хангах, дүрмийг шинэчлэх талаар хэлэлцэнэ гээд байгаа. Мөн АН-ын даргын төлөөх марафон өрнөхөө больж, намын Их хурлаас нууц санал хураалтаар сонгохоор болсон гэх мэдээлэл ч гараад байгаа юм. Үлээсэн шаар шиг хэврэг байгаа АН-ын ҮЗХ-ны энэ удаагийн хурал салаа замын уулзвар дээрх сүүлчийн хурал нь байж, эвлэлдэн нэгдэх эсэх нь тодорхой болох буй заа.

ХААН банк

	Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2400.00	2459.00	ФУНТ	2952.00	3110.00
ЕВРО	2552.00	2670.00	РУБЛЬ	34.90	38.50
ИЕН	22.00	22.98	ЮАНЬ	350.00	360.40

Худалдаа хөгжлийн банк

	Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2400.00	2459.00	ФУНТ	2966.00	3115.00
ЕВРО	2554.00	2684.00	РУБЛЬ	35.45	39.36
ИЕН	21.91	23.07	ЮАНЬ	350.00	360.40

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

E-mail: mongoliin_medee@yahoo.com Утас: 976-70113551 Факс: 976-70113551

УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

Д.Оюунхорол сайд дугуйчдыг хүлээн авч уулзлаа

Сурагч, оюутан, архитектор, хуульч, сэтгүүлч, эдийн засагч гэх мэт 17-57 насны 19 дугуйчин БНСУ-д 660 км унадаг дугуйн аяллыг өнгөрсөн сарын 21-28-ны өдрүүдэд хийжээ. Эх орноо гадаадад сурталчлах шинэ төрлийн хэлбэр бий болгосон тамирчдыг БОАЖ-ын сайд Д.Оюунхорол өчигдөр хүлээн авч уулзан талархал илэрхийлж, өргөмжлөл, дурсгалын цом гардууллаа. Тэрбээр "Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр цаашид авах арга хэмжээний хүрээнд 5, 10 км дугуйн зам барих шаардлагатай. Нийслэл хот хуучин машинаар дүүрсэн энэ үед иргэд бид аль болох агаарын бохирдлын эсрэг өөрсдийн хувь нэмрээ оруулах ёстой. Хуучин машин тоосонцор ялгаруулж, энэ нь хүний эрхтэн дархлааны системийг устгаж, өвчлүүлж байдгийг ДЭМБ-аас тогтоосон. Тиймээс эрүүл орчинд хөдөлгөөнтэй байх замыг иргэд сонгох цаг болсон.Харин төрөөс унадаг дугуйн аялал жуулчлал, дэд бүтцийг хөгжүүлэхэд бодлогоор дэмжиж ажиллах болно" гэв. "МВ" олон улсын унадаг дугуйн холбооноос санаачлан зохион байгуулсан энэхүү аяллын гараа Солонгосын хамгийн хойд цэг болох Пажу хотоос эхэлж хамгийн урд цэг болох Бусанд барианд орох хүртэл 660 км-ийг унадаг дугуйгаар туулсан байна. Энэ хооронд Пажу, Намянжү, Чунжү, Куми, Дэгү, Намжиөп зэрэг хотуудаар дайран өнгөрчээ. Түүнчлэн эх орноо гадаадад сурталчлахаас гадна Солонгосын унадаг дугуйн зам, гүүрэн байгууламж, тэмдэг тэмдэглэгээ, дугуй унах соёлыг судлахад уг аяллын зорилго оршжээ.

ОНЦЛОХ МЭДЭЭ

Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

ЭНЭ САРЫН 17-25-НЫ ӨДРҮҮДЭД -47 ХЭМ ХҮРЧ ХҮЙТРЭХ НЬ

Ж.МЯГМАР

Шадар сайд У.Хүрэлсүхийн тэргүүлсэн Улсын онцгой комиссын хуралдаан боллоо. Онцгой комиссын хуралдаанд Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн, Эрчим хүчний сайд П.Ганхүү, Зам тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Т.Бадрал нарын албаны хүмүүс оролцов. Сүүлийн хэд хоногт цас их хэмжээгээр орсноос нийт нутгийн 30 гаруй хувьд өвөлжилт хүндэрч болзошгүй болжээ. Ингэхдээ зуд тохиолдож болзошгүй аймгуудад Увс, Дорнод, Төв, Хэнтий, Дархан, Сэлэнгийн ихэнх сумд, Завханы хойд, Булганы зүүн өмнөд, Хөвсгөлийн баруун хэсэг хамаарч байна. Мөн Цаг уур, орчны шинжилгээний хүрээлэнгээс өгсөн мэдээллээр арваннэгдүгээр сарын 17-25-ныг хүртэлх хугацаанд манай оронд сүүлийн 10 гаруй жилд ажиглагдаагүй онцгой хүйтэн болох төлөв гарчээ. Тодруулбал, арваннэгдүгээр сарын 16-нд баруун аймгуудын нутгаар, арваннэгдүгээр сарын 17-18-нд ихэнх нутгаар салхи секундэд 18-20 метр хүрч, зарим үед 24 метр хүрч, цасан болон шороон шуурга шуурч, зам даваа хаагдах нөхцөл байдал үүсч болзошгүй байгаа аж. Цаг уур, орчны шинжилгээний хүрээлэнгээс өгсөн мэдээллээр арваннэгдүгээр сарын 17-25-ныг хүртэлх хугацаанд манай оронд сүүлийн 10 гаруй жилд ажиглагдаагүй онцгой хүйтрэх төлөв гарчээ. Мөн арваннэгдүгээр сарын 17-нд нутгийн хойд хэсэг, цаашдаа нийт нутгаар хүйтний эрч эрс чангарч шөнөдөө Увс нуур, Идэр, Туул голын хөндий, Дархадын хотгороор -42-47 градус, Сэлэнгэ, Хараа, Ерөө, Онон, Улз, Туул, Тэрэлж голын хөндийгөөр -35-40 градус хүрч малын бэлчээрлэлт, авто болон төмөр замын тээвэр, дулааны хангамжид хүндрэл учруулах онцгой нөхцөл байдал бүрдэж байгааг анхааруулласан. Одоогийн байдлаар манай орны нийт нутаг дэвсгэрийн 50 орчим хувь нь цастай байгаагаас Баян-Өлгий аймгийн Сагсай сум, Булган аймгийн Бугат, Сэлэнгэ аймгийн Тэшиг, Хангал сум, Дорнод аймгийн Баян-Уул, Баяндун, Баянтүмэн, Дашбалбар, Сэргэлэн, Цагаан-Овоо, Чойбалсан, Хөлөнбуйр сум, Завхан аймгийн Баянтэс, Баянхайрхан, Сонгино, Тэс, Түдэвтэй сум, Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сум, Сэлэнгэ аймгийн Баянгол, Орхонтуул, Орхон, Түшиг сум, Увс аймгийн Баруунтуруун, Зүүнхангай, Сагил, Түргэн сум, Хөвсгөл аймгийн Цагаан-Уул, Цагааннуур, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр, Эрдэнэбулган сум, Хэнтий аймгийн Баян-Адарга, Батноров, Биндэр, Өмнөдэлгэр, Норовлин сумын нутгаар цасны зузаан 11-20 см (нягт 0.10-0.30 гр/см3), Дархан-Уул аймгийн Дархан, Шарын гол сум, Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн, Ерөө, Цагааннуур, Хушаат, Хүдэр сум, Увс аймгийн Зүүнхангай, Малчин, Наранбулаг, Цагаанхайрхан сум, Хөвсгөл аймгийн Улаан-Уул, Ренчинлхүмбэ, Хатгал сум, Хэнтий аймгийн Дадал сумын нутгаар цасны зузаан 21-40 см (нягт 0.12-0.28 гр/см3)-т хүрсэн байна.

П.Сэргэлэн: Энэ өвөл 6.9 сая мал отроор өвөлжинө

Улсын онцгой комиссын хуралдаанд Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн мэдээлэл хийлээ. Тэрбээр "Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах хүрээнд дүн тайлан нэгтгэгдэн гарлаа. Энэ жил улсын хэмжээнд нийт 153.1 мянган малчин өрхөд 60.8 сая, хонин толгойд шилжүүлснээр 100.4 сая толгой малыг өвөлжүүлэх бэлтгэл ажлын зохион байгуулалт хийгдсэн байна. Өвөл, хаврын бэлчээрийн даацын судалгаагаар нийт нутгийн 80.8 хувь нь бэлчээр хүрэлцээтэй, 20.0 хувь нь хүрэлцээ муутайгаас орон нутгийн ЗДТГ отор хийж, өвөлжих өрх, малын тоог тохиролцон гэрээ байгуулан сум дундын отрын бүс нутаг, аймаг, дундын тусгай хэрэгцээний отрын бүс нутаг, хилийн зурвас газар, улсын тусгай хамгаалалттай бүс нутагт нийт 16460 өрхийн 6.9 сая мал отроор өвөлжиж, хаваржих юм. Энэ онд улсын төсвийн 745.1 сая төгрөгөөр 42, гадаадын төсөл, хөтөлбөрийн 371.3 сая төгрөгөөр 27, орон нутгийн төсвийн 2.8 тэрбум төгрөгөөр 259 инженерийн хийцтэй худаг, малчдын санаачлагчаар 354 гар худаг, нийт 682 худаг гаргасан нь 775.2 мянган га бэлчээр, 2.7 мянган малчин өрх, 1.9 сая малын усан хангамжийг нэмэгдүүллээ. Энэ онд бодын 1157, богийн 2042 хашаа саравч шинээр барьж, улсын хэмжээнд бодын 57353 хашаа, богийн 125807 хашаа байгаа нь хашааны хангамж 97.1 хувьтай байна. Бэлчээрийн ургамлыг хамгаалах арга хэмжээний хүрээнд хөнөөлт царцаатай тэмцэх ажлыг хоёр аймагт 45.1 мянган га талбайд, үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг 10 аймгийн 525.0 мянган га бэлчээрийн талбайд байгаль орчинд халгүй энгийн механик аргаар зохион байгуулсан. Энэ ажлын үр дүнд бэлчээрийн даац багтаамжийг нийт 570.1 мянган га-аар нэмэгдүүлэх боломжийг бүрдүүллээ. Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг малчдын өвс, тэжээл бэлтгэл, аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэлт, ус, хашааны хүрэлцээ хангамж, малчин өрхийн бэлтгэл зэрэг үндсэн үзүүлэлтүүдээр дүгнэхэд улсын хэмжээнд 82.8 хувьтай хангасан дүн гарлаа" гэв. Энэ жилийн хадлан бэлтгэх ажилд 7101 дугуйт трактор, 5806 бага оврын тракторууд дагалдах хэрэгслийн хамт, 621 хаман боогч, 1000 морин хадуур, 5000 гар болон хөдөлгөөнт хадуур, тармуур ажиллаж малчдын төвшинд өвс 1.1 сая тонн, сүрэл 35.8 мянган тонн, ногоон тэжээл 22.3 мянган тонн, үйлдвэрийн тэжээл 27.1 мянган тонн, гар тэжээл 38.1 мянган тонн, дарш 8.0 мянган тонн, давс, хужир 105.6 мянган тонн бэлтгэгджээ.

Станцууд 12–40 хоногийн нүүрсний нөөцтэй гэв

Эрчим хүчний сайдын П.Ганхүүгийн өгч буй мэдээллээр арваннэгдүгээр сарын 11-ний байдлаар, ТЭЦ IY – 185171 тн буюу 18 хоногийн, ТЭЦ III – 56 890 тн буюу 12 хоногийн, ТЭЦ II – 8 376 тн буюу ес хоногийн, Дарханы цахилгаан станц – 35 877 тн буюу 27 хоногийн, Эрдэнэтийн дулааны станц – 39 773 тн буюу 40 хоногийн, Амгалан станц – 10 986 тн буюу 21 хоногийн нүүрсний нөөцтэй байна. Харин Зам тээврийн хөгжлийн сайдын мэдээллээр авто замын засвар, арчлалтын ажлын өвөлжилтийн бэлтгэл ажил хангах төлөвлөгөөний биелэлт 94.4 хувьтай байгаа аж. Улс, хот хоорондын болон нийтийн зорчигч тээвэрлэлт гүйцэтгэж буй 53 аж ахуйн нэгжийн 418 тээврийн хэрэгслийг техникийн хяналт үзлэгт бүрэн хамруулж техникийн бүрэн бүтэн байдлыг хангуулан ажиллаж буй юм байна. Нийтийн тээврийн үйлчилгээг хэвийн явуулахад хөдлөх бүрэлдхүүний шаардлагатай сэлбэг хэрэгсэл, өвлийн улирлын шатахуун, тослох материал, хөлддөггүй шингэн, спиртийн нөөцийг зохих хэмжээнд нөөцлөн бэлтгэлийг хангасан. Орон нутгийн 15 нисэх буудалд шатахууны агуулахын техник үйлчилгээг хуваарийн дагуу хийж гүйцэтгэсэн. Баян-Өлгий, Завхан, Өвөрхангай, Ховд, Хөвсгөлийн Мөрөн, Өмнөговь, Дундговь аймгийн нисэх буудлын засварын ажлын гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж засварын ажил хийгдэж байна. Орон нутгийн нисэх буудал бүгд шатах тослох материал, түлээ, нүүрсээ нөөцөлжээ.

Онцгой комиссын хуралдааны төгсгөлд Шадар сайд У.Хүрэлсүх холбогдох сайд нарт захиас, даалгаврыг үүрэг болгосоноор энэ удаагийн Улсын онцгой комиссын хуралдаан өндөрлөлөө.

MMINFO.

МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 88873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Э.ЭНХЦЭЦЭГ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг:
Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот

Харилцах утас, факс:
976-70113551

"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ШАДАР МЭДЭЭ

"Эрдэнэт"-ийн захирлын төлөө МАН-ын фракциуд хагаралдаж эхэллээ

ЗГХЭГ-ын дарга Ж.Мөнхбат "Эрдэнэт" үйлдвэрийн захирлаар хэнийг тавих вэ гэдэгт нэгдсэн шийдэлд хүрээгүйгээс өнөөдрийг хүртэл уг томилгоог хийхгүй байгаагаа учирлав. Олгой хагаравч тогоондоо гэгчээр МАН доторх фракциуд "Эрдэнэт"-ийн удирдлагаас болж "дайтаж" байгаа ч үүнийгээ "Хүний нөөцийн хувьд нэгдсэн шийдэлд хүрээгүй байна" хэмээн зөөлхөн мэдээлсэн нь энэ.

Уг чанартаа МАН доторх хотын фракциас хуучин захирал асан Ч.Ганзоригийг, Сү.Батболд болон С.Баярын фракциас Эрчим хүчний сайд асан Д.Зоригтыг, Ц.Нямдорж толгойтой Увсын фракци Г.Алтанг зүтгүүлж байгаа аж. Эдгээрээс аль нь өөрийн хүнээ "Эрдэнэт"-ийн захирлаар томилуулж чадна, тэдний санхүүгийн асуудал бүрэн шийдэгдэнэ гэсэн үг.

Томчууд нь захирлын суудлын төлөө "алалцаж" байх хооронд залуучуудын фракци нь дэд захирал, хангамжийн алба, санхүү хариуцсан захирал зэрэг албан тушаалд хүмүүсээ томилуулахаар улайрч байна. Тиймээс энэ өрсөлдөөн Ц.Нямдоржийн хэлснээр ирэх оны дөрөвдүгээр сар хүртэл сунжрах магадлал өндөр байна.

БАЙНГЫН ХОРОО

Ч.Хүрэлбаатар: ТӨСВИЙН САХИЛГА, ХАРИУЦЛАГЫГ ЧАНГАТГАХ ЧИГЛЭЛ ӨГСӨН

Ж.ОТГОН

УИХ-ын Төсвийн байнгын хорооны хуралдаан гишүүдийн 52.6 хувийн ирцтэйгээр хуралдав. Хуралдаанаар Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийсэн юм.Тогтоолын төсөлд хууль, эрх зүйн орчныг сайжруулах, төсвийн орлогыг нэмэгдүүлэх, төсвийн зардлыг хэмнэх, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын менежментийг сайжруулах гэсэн дөрвөн чиглэлээр 16 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгахаар тусгасан байна. Тухайлбал, татвараас зайлсхийх нөхцөлийг бүрдүүлж байгаа зарим асуудал, татварын орлогод нөлөөлж байгаа татварын хөнгөлөлт чөлөөлөлтийг багасгах, хөрөнгө оруулалтын таатай нөхцөлийг бүрдүүлэх, төсвийн төслийн боловсруулалт болон хэрэгжилтэд тавих хяналтыг боловсронгуй болгох чиглэлээр УИХ-д саналаа боловсруулж танилцуулах зэргийг тусгасан байна. Түүнчлэн нүүрсний экспортын үнийг дэлхийн зах зээлийн үнийн төвшинтэй нийцүүлэх, түүхий нефтийн экспортоос холбогдох татварыг тооцдог болох, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн ашиг, орлогыг нэмэгдүүлэх, зардлыг багасгах, төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд тухайн салбарын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төлөөлөл орох, тэдний цалин, урамшуулыг оновчтой болгох зэрэг асуудлыг тусгасан байлаа. Байнгын хорооны дарга Ч.Хүрэлбаатар 2016 оны төсвийн тодотгол батлагдсантай холбогдуулж авах арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төсөлд төсвийн төсвийн сахилга, хариуцлагыг чангатгах талаар илүүтэй чиглэл өгсөн. Харин 2017 оны төсвийн хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай тогтоолын төсөлд бид төсвийн зардал хэмнэх чиглэлд анхаарсан. Түүнчлэн тогтоолын төсөлд тусгагдсан арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлсэн талаархи тайланг Төсвийн байнгын хороонд гурван сар тутам танилцуулж байхаар болсон гэдгийг онцолж байлаа.

Хуралдааны үеэр УИХ-ын дэд дарга Ц.Нямдорж "Эрдэнэт" үйлдвэрийн ерөнхий захирлыг яагаад шинээр томилохгүй байна вэ гэдэг асуудал хөндөгдөв. Тэрбээр "Засгийн газар "Эрдэнэт" үйлдвэрийн 51 хувийг эзэмшиж байгаа. Тийм байтал яагаад одоог болтол энэ үйлдвэрийн ерөнхий захирлыг томилохгүй байна вэ. Надад байгаа мэдээллээр бол ирэх оны дөрөвдүгээр сарын 18-ны хүртэл "Эрдэнэт"-ийг хуучин ерөнхий захирал нь удирдана гэх. Энэ ямар учиртай юм бэ" гэдгийг тодруулсан. Харин Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат "Өнөөдрийн хувьд хэн "Эрдэнэт"-ийн ерөнхий захирал болох вэ гэдэг дээр нэгдсэн шийдэлд хүрэх шаардлага байна. Засгийн газар яаралтай томилъё гэсэн байр суурьтай байгаа. Гэхдээ хэнийг томилох вэ гэдгээ бодлогын төвшинд эхлээд шийдэх ёстой. "Эрдэнэт"-ийн Төлөөлөн удирдах зөвлөл өнөөдөр хуралдахад ч бэлэн. Гагцхүү хүний нөөцийн хувьд хэн байх вэ гэдэг шийдэлд хүрээгүй байгаа юм" гэв. Улмаар УИХ-ын Төсвийн байнгын хорооны дарга Ч.Хүрэлбаатар "Эрдэнэт" үйлдвэрийн ерөнхий захирлаар томилох хүн олдохгүй байгаа юм байна. Дараагийн асуудлаа хэлэлцье" гэснээр 2017 оны төсөв батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төслийн эцсийн хэллэцүүлгийг хийж, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулахаар болж шийдвэрлэснээр УИХ-ын Төсвийн байнгын хорооны хуралдааныг өндөрлүүлсэн юм. УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдааны тухайд Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрт нэгдэн орох тухай асуудлыг хэлэлцэн дэмжиж, саналаа Засгийн газарт хүргүүлэхээр болсон. Харин УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанаар "Хог хаягдлын тухай /шинэчилсэн найруулга/ хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг буцаах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжсэн юм.

ҮЗЭЛ БОДОЛ

10 ТЭРБУМЫН АШИГТАЙ АЖИЛЛАДАГ “МОНГОЛ ШУУДАН” КОМПАНИЙГ ХУВЬЧЛАХ ГЭЖ ЯАРАХЫН УЧИР ЮУН

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Гэхдээ л “Монгол шуудан” компани үүнээс бага үнээр хувьчлагдахаар болж байгаа нь арай дэндсэн хэрэг биш үү. Хамгийн гол нь энэ компанийн дансанд есөн тэрбум төгрөг байгаа талаар УИХ-ын гишүүн Т.Аюурсайхан өнгөрсөн даваа гарагт “Нүүдэл, шийдэл” нэвтрүүлэгт оролцох үеэрээ мэдээлсэн. Нэвтрүүлгийн энэ удаагийн сэдэв нь “Өмч хувьчлал” байсан юм. Тиймдээ ч нэвтрүүлгийн үеэр тодорхой баримттай мэдээлэл өгсөн нь тэр. Ер нь бол мань хүн “Монгол шуудан” компанийн 34 хувийг нь IPO гаргаад 6.1 тэрбумаар борлуулчихсан. Тэр 6.1 тэрбум төгрөг дансанд нь байгаа. Дээр нь таван тэрбум төгрөгөөр үнэлэгдэх марк байна. Марк гэдэг төгрөгтэй ижил хэмжээнд бодогддог үнэт зүйл” хэмээн ярьж байсан. Ямар ч байсан энэ компанийн дансанд багагүй мөнгө байгаа нь тодорхой байна. Дээрээс нь жилдээ 10 тэрбумын ашигтай ажилладаг. Энэ ашгийнх нь ихдээ л 60 хувь нь цалин хөлс, зардалдаа явдаг гэж байгаа. Тэгэхээр жилдээ дөрвөн тэрбумын цэвэр ашгийг улсад өгч байна гэсэн үг. Ийм ашигтай ажилладаг, төрөөс алдагдал гарлаа, өр дараад өгөөч гэж гуйдаггүй төрийн өмчит компани хэд билээ. Бодох л асуудал.

Монголд өмч хувьчлал захиалгатай явагдаад байна уу

Төр засгийнхан бол улсын төсөвт орлого оруулах үүднээс төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг хувьчилж байгаа гэх. Цаашлаад алдагдалтай ажилладаг компаниудыг цэгцэлж, төрийн нуруун дээр ирдэг дарамтыг багасгах зорилготой ч гэдэг. Үнэхээр алдагдалтай ажиллаж байгаа, хувьчлах шаардлагатай компаниудыг хувьчлах нь зөв. Ер нь төр муу менежер гэдгээ 70 жилийн турш баталсан гэдгийг ухаантай хүмүүс хэлээд байгаа. Тэгээд ч 30-хан хүнтэй төрийн мэдлийн байгууллагын дарга 10 сая төгрөгийн цалин авдаг жишээ хүртэл байгааг учир мэдэх, мэдээлэлтэй хүмүүс ярьж байна. Энэ мэт асуудлыг цэгцлэх л хэрэгтэй. Гэхдээ “чоно бороноор” гэгчээр энэ мэт асуудал ярьж байгаад хажуугаар нь далимдуулж, ашигтай ажиллаж байгаа, хувьчилж болохооргүй газруудыг хувьчилдаг, захиалж авдаг байдал гараад байна уу гэх асуулт байна. Бүр тодорхой хэлбэл, “Монгол шуудан” компанийг хэн нэгний захиалгын дагуу тун хямдхан үнээр хувьчилж байгаа юм биш биз. Ер нь энэ хувьчлалын цаана МАН-ын нөлөө бүхий улстөрч, бүр тодруулбал УИХ-ын гишүүн Сү.Батболд гэдгийг эх сурвалжууд мэдээлж буй. Тиймдээ ч УИХ-ын гишүүд ганц үг ган хийхгүйгээр 20 тэрбумаар хувьчлахыг нь хоёр гараа өргөх шахан дэмжсэн ч байж болох. Уг нь шуудангийн салбарыг төр өөрөө эзэмшиж байх ёстой юм. Хэрвээ үнэхээр хувьчлах шаардлагатай гэж үзвэл 49 хувийг нь л хувьд өгнө биз дээ. Төр өөрөө 51 хувиа мэдээд байж байхад яадаг юм, ямар алдагдалтай ажиллаад байгаа биш. Дээрээс нь төрийн нууцтай холбоотой мэдээлэл шуудангаар дамждаг. Хэрвээ хувьчилчихвалэнэмэтмэдээлэл алдагдаж, асуудал үүсвэл яах болж байна. Хамаагүй явуулаад байх юм уу. Явуулаа гэхэд нууцыг нь хангах асуудлыг яах юм.

Өнөөдөр “Монгол шуудан”-гаар дамжуулаад бүхий л хэвлэлийг Улаанбаатар хотод төдийгүй, хөдөө орон нутагт тарааж байгаа. Хувьчилж авах хүмүүс нь гарч ирээд хэдэн хэвлэлийг боомилж эхэлбэл яана. Энэ утгаараа “Монгол шуудан”-г хувьчлах асуудлаа эргэж хармаар байна. Тэгээд 20-хон тэрбумаар шүү. “Монгол шуудан”-гийн барилга, байршил, цаашлаад 330 суманд байгаа салбарын барилга, байгууламж огт үнэлэгдэхгүй гэсэн үг үү. Монголын бүхий л суманд салбартай, байшин барилгатай ганц төрийн өмчит байгууллага байгаа нь “Монгол шуудан”. 130 гаруй автомашинтай гэж байгаа. Энэ бүхэн нийлээд 20 тэрбум төгрөг боллоо гэж үү. Яав ч тийм байж таарахгүй. Ингээд бодохоор “Монгол шуудан”-гийн хувьчлал цэвэр захиалгын дагуу яваад байгаа юм биш үү. МАН-ын нэг нөхөр “Монгол шуудан”-г ийм хямд, бараг үнэгүй шахам авчихаад олон зүйлийг “базаж” болохоор болно. Тиймдээ ч төсөвт 20 тэрбумыг оруулах нэрийдлээр луйвардаж авах гэсэн байна даа.

Дугаарын **60** мөр

“Аз жаргал”-ын биш аваар, ослын хот боллоо

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Тодруулбал, зөвхөн арваннэгдүгээр сар гарснаас хойш гэхэд л нийт 1344 хүнд яаралтай тусламж үзүүлсэн гэж байна. Гэмтлийн эмнэлгийн энэхүү мэдээллээс харвал их хотын иргэд хэдэн зуугаараа хальтиргаа гулгаанаас болж, гар хөлөө гэмтээж эмчилгээний зардалд олон саяар нь хөрөнгө мөнгөө зарцуулж байна.

Гэтэл гудамж талбайн цасыг цэвэрлэх учиртай хүмүүс “Төсөв мөнгөний хүрэлцээ муу учраас давс бодисоо хэмнэж, цасаа шүүрдэж цэвэрлэж байна” гэсэн тайлбар хийгээд л хэнэг ч үгүй сууж буй. Ийнхүү цасаа шүүрдэж цэвэрлэх гэж байна хэмээн цаг алдах зуур өнөөх цас нь аль хэдийнэ мөсөн тэшүүр болчихоод байна. Тиймээс ч иргэд өдөр бүр цаг, минут тутамд эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирсоор л.

Хамгийн энгийн жишээ гэхэд хүн хальтирч унаснаас болж зөөлөн эдээ гэмтээвэл хамгийн багадаа зургаан сар, хөдөлмөрийн чадвартай болох хүртэл 1-1.3 жилийн хугацаа шаардлагатай байдаг гэдгийг эмч, мэргэжилтнүүд хэлдэг. Мөн явганаас унасны улмаас нас барсан тохиолдол ч байдаг. Тэгвэл нэг өдөрт хэчнээн хүн явганаас унаж, хөдөлмөрийн чадвараа алдаж байгаа бол. Мэдээж нэлээд өндөр тоо гарна. Тэгвэл тэдний гэртээ байсан өдрүүдийн цалин, эмчилгээний төлбөрийг хэн өгөх билээ. Цасаа цэвэрлэхгүй байгаа нийслэлийн дарга нар л лав өгөхгүй нь мэдээж. Тиймээс нэн даруйхан арга хэмжээ авч, цас мөсний хотоо цэвэрлэхгүй бол бүгдээрээ группт орж мэдэхээр байна.

Замын хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслүүд ч сүүлийн хэдэн өдөр ёстой л жингүйдэж байгаа мэт мөлхөж байна. Хэдийгээр жолоох нар удаан, анхаарал болгоомжтой замын хөдөлгөөнд оролцож байгаа ч шил, толь шиг болсон зам дээр чинь мөргөлдөж, осол аваар гарсаар байна. Нэг жолоох хальтиргаатай замаас болоод осол гаргалаа гэхэд хамгийн багадаа 100 мянган төгрөгийн төлбөрт унадаг гэдгийг мэднэ биз дээ.

Яг үнэндээ нийслэлийн шинэ удирдлагууд гуравхан өдөр орсон цасны шалгалтад “F” дүн авлаа. Цаашдаа ч цас нэмэгдэж орно. Учир нь өнөөдөр Улсын онцгой комиссын ээлжит хуралдаан Төрийн ордон буюу Шадар сайдын өрөөнд болсон. Энэ хурлаар 16-18-ны өдрүүдэд цаг агаарын онцгой үзэгдэл болох талаар мэдээлж байна. Иймээс хотын удирдлагууд болон албан байгууллагууд ч хальтиргаа гулгаанаас сэргийлж, зам талбайгаа цэвэрлэхэд анхаарал хандуулах шаардлагатай байна. Үнэндээ “Аз жаргалтай хот”-ыг цогцлоож сүйд болдоггүй юм гэхэд өдөр бүр гарч буй аваар, ослоор амь нас, эрүүл мэндээрээ хохирч байгаа иргэддээ ядаж зам талбайг нь цэвэрлэж, цасаа хайлуулж, давсаа цацаж хайрлаач, хотын дарга аа.

ЗАЛУУСЫН ХОТХОН
X Apartment
ЯПОН ЧАНАР

Та бүхэндээ 100% ашиглалтанд орсон, Япон архитекторын орон зайн тегс зохион байгуулалт бүхий Залуусын хотхон “X Apartment”-ыг танилцуулж байна. Хотын А зэрэглэлийн бүсэд байрлах Залуусын хотхон “X Apartment” нь оршин суугчдын тав тухыг дээд зэргээр хангахаар төлөвлөгдсөн хамгийн бодит үнэтэй орон сууц юм. Урьдчилгаа 10-20% төлөөд байрандаа нүүж орох боломжтой тансаг зэрэглэлийг илтгэх, дотроо 2 давхар, void буюу 2 давхараас шууд харагдах хоосон орон зай бүхий **Тансаг зэрэглэлийг илтгэх ДУПЛЕКС загварын орон сууц**

- ЗГ-аас хараахьгүй буй 8% зээлээ 7 хоногт шийдвэрлүүлэх:

Та 100% ашиглалтанд орсон орон сууцнаас сонголтоо хийж, бидэнтэй хамтран ажилладаг Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, Хаан банк, Төрийн банкуудаар тусгайлан үйлчлүүлж 8% зээлээ 7 хоногийн дотор шуурхай шийдвэрлүүлэх таатай боломжийг санал болгож байна.

- Албан байгууллага, хамт олноороо сонголт хийсэнээр адлэх тусгай хөнгөлөлт:

Хамт олноороо бэлэн болсон орон сууцнаас сонголт хийж үнийн хөнгөлөлт, авто машины зогсоолын хөнгөлөлт, Монтессори сургалттай цэцэрлэгт хүүхдээ үнэгүй суралцуулах эрх зэрэг таны тав тухтай амьдрахад чиглэсэн бодит хөнгөлөлтүүдийг санал болгож байна.

- Бизнесмен танд зориулсан үян хатан нөхцөл:

Та өөртөө болон байгууллагын хамт олондоо зориулан манай орон сууцнаас сонголт хийж, өөрийн эрхлэн явуулдаг бизнес болох барилгын сайн чанарын материалууд болон арматураар хаалцан ашигтай хамтран ажиллах боломж бүхий таатай нөхцлийг санал болгож байна

- Банкны хүүгүйгээр өөрийн болгох боломж:

Амжилтай яваа бизнесмен Танд зориулан өөрийн таалалд нийцсэн орон сууцыг бидний нэрлэсэн үнээр худалдан авч, төлбөрийн 50 хувийг төлөөд үлдэгдэл төлбөрөө 1-2 жилийн дотор хүүгүйгээр төлөх төлбөрийн нөхцлийг онцгойлон санал болгож байна.

TDB ХААН БАНК ТӨРИЙН БАНК ГОЛОМТ БАНК XACBANK

Барилгын нэгдүгээр давхарт 24 цагийн харуул хамгаалалт, нэгдсэн лобби танхим бүхий таныг угтах ресепшн хэсэг, дулаан авто зогсоол болон оршин суугчдын хэрэгцээг бүрэн хангах бүх торлийн үйлчилгээний төвүүдийг толовлосон бүрэн цутгамал орон сууц юм.

ОРШИН СУУГЧДЫНХАА ТАВ ТУХ, ЭРҮҮЛ БАЙДЛЫГ ЭРХЭМЛЭЖ ДЭЛХИЙД ЧАНАРААР ТЭРГҮҮЛЭГЧ БРЭНДҮҮДЭЭР “X APARTMENT”-ЫГ ТОНОГЛОЛОО

VEKA ГЕРМАН БАКУМ ЦОНХ | TOTO ЯПОН САНИЙН ТОНОГЛОЛ | LG Hausys СОЛОНГОС ОБОЙ | NIPPON PAINT ЯПОН БУДАГ, ЭМУЛЬС | EGGER АВСТРИ ПАРКЕТАН ШАЛ | ThyssenKrupp ГЕРМАН ЦАХИЛГААН ШАТ | AQUATHERM ГЕРМАН ХОЛБОХ ХЭРЭГСЭЛ | MEGAWOOD MEGAWOOD ХААЛГА

Х-Апартментын хаяг: Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордоны зүүн урд талд
Захиалга авах хаяг: Сүхбаатар дүүрэг Улсын драмын театрын хойд талд "УЛААНБААТАР ПРОПЕРТИЗ" ХХК өөрийн байранд
www.xapartment.mn УТАС: 88002312, 88030203
www.ubproperties.mn УТАС: 96066329, 77009919

ДЭЛХИЙ

ОХУ-ЫН САЙД ҮЙЛДЭЛ ДЭЭРЭЭ БАРИВЧЛАГДЖЭЭ

Б.ДАВААХҮҮ

ОХУ-ын Мөрдөх товчоо төрийн мэдэлд байсан газрын тосны компанийн хувьцаа худалдсан хэргийг шалгаж эхэлжээ. Улмаар уг хэрэгт холбогдуулан тус улсын Эдийн засгийн хөгжлийн сайд Алексей Улюкаев их хэмжээний авлига авсан хэрэгт нэр холбогдон баривчлагдлаа. Тодруулбал, Улюкаевыг төрийн мэдлийн Башнефть компанийн хувьцааг худалдах гэрээг үзэглэх үед газрын тосны Роснефть компаниасхоёрсаяам.долларын авлига авсан гэх үндэслэлээр буруутган саатуулсан байна. Мөрдөх товчооны албан ёсны мэдээллээр эрхэм сайд энэ сарын 14-нд "Носнефть" компанийн албаны төлөөлөгчөөс их хэмжээний бэлэн мөнгөний авлига авах гэж байгаад үйлдэл дээрээ баригдсан гэх. Тэрбээр Засгийн газрын чухал гишүүдийн нэг бөгөөд томоохон эдийн засгийн хэлэлцээрүүдийг хариуцан ажилладаг юм. Энэ долоо хоногийн сүүлээр гэхэд, Өмнөд Америкийн Перуд болох Ази Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны чуулга уулзалтын үеэр Японы төлөөлөгчидтэй уулзаж, хоёр улсын хооронд хийгдэх гэрээний талаар хэлэлцэх төлөвлөгөөтэй байжээ. Гэсэн ч, чуулга уулзалтаас өмнө Алексей Улюкаев баривчлагдсанаар гэрээ хэлэлцээр удаашрах вий гэдэгт япончууд санаа зовниж эхэлсэн байна. Хуучин Зөвлөлт холбоот улс задран унасан 1991 оноос хойш анх удаагаа авлигын хэргээр шалгагдан баривчлагдсан төрийн өндөр дээд албан тушаалтан нь А.Улюкаев болж байна. Албан тушаалаа урвуулан ашиглаж, Роснефть компаниас хахууль "нэхэн" сүрдүүлж, авлига авсан сайд их хэмжээний мөнгөө улаан гараараа барьж байгаад баригдсан гэдгийг ч Мөрдөх товчооны төлөөлөгч "Риа Новости" агентлагт ярьжээ. Тэрбээр гэм буруутай нь тогтоогдвол 8-15 жилийн хорих ял сонсох юм. Төрийн мэдлийн Роснефть компани өнгөрсөн аравдугаар сард Башнефть компанийн 50 хувийг 330 тэрбум рублиэр худалдан авсан байдаг. Роснефть компанийн албаны төлөөлөгч ч гэсэн "Улсын хууль дүрмийн дагуу хамгийн шилдэг арилжааны саналд үндэслэн худалдан авсан" гэдгээ онцолж байна. Хамгийн гол нь Эдийн засгийн сайд Алексей Улюкаев энэ гэрээг амжилттайгаар гүйцэтгэхэд Роснефть компанийн талд үйлчилж, үүнийхээ төлөө дээрх хэмжээний дүн бүхий авлигыг авсан бололтой. Тэрбээр ОХУ-ын Төв банкны орлогч захирлаар 10 жилийн турш ажиллаж байгаад 2013 оноос Эдийн засгийн сайдаар томилогдож байв.

Алексей Улюкаев гэж хэн бэ

Алексей Улюкаев 1956 оны гуравдугаар сарын 23-нд Москвад төржээ. Тэрбээр эдүгээ 60 настай. 1979 онд Москвагийн их сургуулийн Эдийн засгийн факультетийг төгсч, үүнийхээ дараа 2000 онд В.Путины Засгийн газарт Сангийн сайдын нэгдүгээр орлогчоор ажиллаж байжээ. Түүнчлэн, Төв банкны нэгдүгээр орлогч даргаар ажиллаж байсан туршлагатай юм. Улмаар Медведевийн Засгийн газарт 2013 оны зургадугаар сараас хойш Эдийн засгийн хөгжлийн сайдын албан тушаалыг хашиж байна. 20 гаруй жилийн турш тэрбээр ОХУ-ын Засгийн газрын эдийн засгийн бодлоготой холбоотой асуудлыг шийдвэрлэхэд оролцож ирсэн бөгөөд хамгийн сүүлд гэхэд газрын тосны үнийн уналттай холбоотой рублийн ханшийн сулралт, Украины нөхцөл байдалтай холбоотойгоор барууны орнуудын тус улсын эсрэг авсан эдийн засгийн хориг арга хэмжээ гэх мэт улс орны эдийн засгийн асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж иржээ. Алексей англи, франц хэлээр чөлөөтэй ярьдаг бөгөөд хоёр хүү, нэг охинтой аж. Сонирхуулахад, "панамын баримт" гэх нэрээр дэлхий дахинаа цацсан оффшортой холбоотой материалд түүний хүүгийн нэр холбогдож байсан удаатай.

> ...1979 онд Москвагийн их сургуулийн Эдийн засгийн факультетийг төгсч, үүнийхээ дараа 2000 онд В.Путины Засгийн газарт Сангийн сайдын нэгдүгээр орлогчоор ажиллаж байжээ. Түүнчлэн, Төв банкны нэгдүгээр орлогч даргаар ажиллаж байсан туршлагатай юм...

Польш зургаан жилийн өмнөх ослыг дахин шалгана

2010 оны дөрөвдүгээр сард Польшийн Засгийн газрын хэрэглээний нисэх онгоц ОХУ-ын баруун этгээдийн Смоленскийн зах хэсэгт сүйрсэн билээ. Ослоор Польш улсын экс Ерөнхийлөгч Лех Качински нарын хүмүүс амь үрэгдсэн байдаг. Онгоцны ослын шалтгаан эдүгээ тодорхойгүй хэвээр байдаг юм. Тэгвэл тус улсын албаныхан ослын хэргийг дахин шалгаж, шалтгааныг тодруулах ажлыг эхлүүлсэн байна. Улмаар үүнтэй холбогдуулан экс Ерөнхийлөгч нарын булшийг дахин ухаж, гарган шинжилж эхэлжээ. Өмнөх Засгийн газрын үед цаг агаарын нөхцөл байдал болон нисгэгчийн буруутай үйлдлийн улмаас онгоц сүйрсэн гэх дүгнэлт гарсан байдаг. Гэвч, эл дүгнэлтийг өнөөгийн эрх баригч "Хууль, шударга ёс" нам хүлээн зөвшөөрөхгүй байгаа төдийгүй, хуйвалдаан орсон байж болзошгүй хэмээн үзэж буй аж. Тиймээс хэргийг дахин сөхөж эхэлсэн байна.

Польшийн дөрөв дэх Ерөнхийлөгч Лех Качински ихрийн өрөөсөн байсан гэдэг. Харин түүний ихэр ах болох Ярослав Качиньский "Хууль, шударга ёс" намын дарга нь юм. 2010 оны ослоор 96 хүн хохирогч болсон бөгөөд тэдний хамгийн багадаа 83-ынх нь цогцсыг дахин гаргаж, жил орчим хугацаанд шинжлэхээр төлөвлөжээ. Гэвч талийгаачдын ясыг дахин ухаж гаргах нь хэтэрхий хэрцгий үйлдэл гэж үзэн эсэргүүцэх хүн олон байгаа аж.

Газар хөдлөлтийн улмаас жижиг суурингууд тусгаарлагджээ

Даваа гарагт хүчтэй газар хөдлөлт болсонтой холбоотойгоор хүнд хэцүү байдалд орсон жижиг суурин газар, тосгодын оршин суугчдыг аварч, тэдэнд туслахын тулд Шинэ Зеландын Засгийн газар тэнгисийн цэргийн хүчнийхнийг илгээжээ. Тус улсын Өмнөд аралд болсон 7.8 баллын хүчтэй газар хөдлөлтийн улмаас учирсан хохирлын хэмжээ хараахан тодорхойгүй байна. Холбогдох албаны хүмүүсийн хэлснээр, газар хөдлөлтийн улмаас хоёр хүн амиа алдаж, хэд хэдэн хүн гэмтэж бэртсэн юм. Гол гол замууд хаагдсаны улмаас жижиг суурин газрууд тусгаарлагджээ. Жуулчид олноороо очдог Кайкоура хотоос 600 орчим оршин суугч болон хэдэн зуун жуулчин гарах боломжгүй болоод байгаа юм. Энэ хот нь газар хөдлөлтийн голомтоос 60 орчим км зайтай ажээ. Даваа гарагийн үүрээр 7.8 баллын хүчтэй газар хөдлөлт болсноос хойш тус улсад наад зах нь таван баллын хүчтэй газар хөдлөлт 21 удаа болсон гэж АНУ-ын Геологийн судалгааны газар мэдэгдлээ. Тэдгээрийн дөрөв нь зургаа болон түүнээс дээш баллын хүчтэй байжээ. Цаашид дахин газар хөдлөлт болж болзошгүй учир сонор сэрэмжтэй байхыг оршин суугчдад албаны хүмүүс анхааруулж байна.

Бугуйн цаг 11 сая франк хүрчээ

Швейцарийн тансаг зэрэглэлийн цаг үйлдвэрлэгч "Патек Филиппе" компанийн зэвэрдэггүй гангаар хийсэн "Ref.1518" бугуйн цаг тус улсын нийслэл Женев хотод дуудлага худалдаагаар зарагджээ. Улмаар түүхэн дэх хамгийн их үнэд хүрсэн цагаар нэрлэгдлээ. Цаг 11 сая франкийн үнэ хүрсэн аж. Дуудлага худалдаа энэ сарын 12-ны өдөр болсон бөгөөд цаг дуудлага худалдаа эхэлснээс ердөө 13 минутын дотор зарагджээ. Үнэ хаялцуулах худалдаа ч тун өрсөлдөөнтэй болсон гэнэ. Одоогоор цагийг худалдсан болон худалдан авсан хүмүүсийг зохион байгуулагчдын зүгээс нууцалж байна. "Ref.1518" бугуйн цаг 1941 онд үйлдвэрлэгдсэн бөгөөд дэлхийн хамгийн анхны тасралтгүй үргэлжлэх календар болон секундомераар тоногложээ.

Хэрэгцээндээ нийцсэн УГААЛГЫН МАШИНЫГ хэрхэн сонгох вэ?

Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн МВА хөтөлбөрийн оюутан Б.БУЛГАН

Айл гэрт байх хамгийн хэрэгцээтэй цахилгаан барааны жагсаалтад хөргөгч, зурагт, угаалгын машин, плитка зэрэг хамгийн наад захын хэрэгцээ шаардлага хангах бараа бүтээгдэхүүнүүд орно. Судалгаанаас үзэхэд, сүүлийн жилүүдэд манай улсад угаалгын машины эрэлт нэмэгдэж байгаа нь нэг талаас орон сууцны нийлүүлэлт жилд ойролцоогоор 25 орчим хувийн өсөлттэй байгаа, нөгөө талаас өрхийн хэрэгцээт гэр ахуйн бараанаас зурагт, хөргөгч, плиткыг 100 өрхийн 88-76 нь хэрэглэдэг нь судалгаагаар тогтоогдсон бөгөөд энэ нь тухайн бараануудаар хэрэглэгчдийн хэрэглээ хангагдсан. Иймээс дахин шинээр худалдах авах нь харьцангуй бага зэрэг хүчин зүйлтэй холбоотой. Монгол Улсын импортын мэдээнээс харахад 2013 онд гэр ахуйн цахилгаан барааны зургаан хувь, 2015 онд 10 хувийг угаалгын машин эзэлж байсны дээр "Самсунг" , "Эл Жи", BSB, Haier, Hitachi, Akira, Beko, Electorolux, Indesit гэх мэт нэлээд олон брэндийн угаалгын машиныг оруулж ирдэг байна. Иймд та бүрэн болон хагас автоматын алиныг нь, ямар брэндийн угаалгын машин сонгохоо мэдэхгүй эргэлзэж байна уу? Аль нь таны мөнгө болон цаг хугацааг хэмнэх бол?

Гэр ахуйн цахилгаан хэрэгслийн дотроос хамгийн их эрчим хүч зарцуулдаг нь угаалгын машин болон плитка юм. Бүрэн автомат угаалгын машин нь усаа халаах болон хүчтэй мотор зэргээсээ хамааран эрчим хүчний зарцуулалт их байдаг. Иймээс угаалгын машин үйлдвэрлэгч компаниудын эн түрүүний зорилго бол угаалгын машины эрчим хүч зарцуулалтыг багасгах, мөн бага усаар угаадаг машин үйлдвэрлэн нийлүүлэх явдал байсаар ирсэн учраас гэр ахуйн гол хэрэгцээтэй бараа болох зурагт, хөргөгч, плитка зэрэг цахилгаан бараанаас хамгийн их технологийн шинэчлэл хийгдсэн цахилгаан барааны нэгд угаалгын машин зүй ёсоор ордог.

Европын холбооны улсын гэр ахуйн цахилгаан бараа үйлдвэрлэгчдийн холбооноос бүрэн автомат угаалгын машины стандартыг 1997 оноос хойш хэд хэдэн удаа шинэчлэн тогтоосон бөгөөд хамгийн сүүлд ECO-системийг шинээр гаргажээ. 2003 оноос өмнөх бүрэн автомат угаалгын машин нь нэг удаагийн угаалтдаа ойролцоогоор 130 орчим литр ус хэрэглэдэг байсан бол 2003 оноос хойш шинэ технологи гарсанаар нэг удаагийн угаалтад хэрэглэдэг усны зарцуулалт нь бараг гурав дахин бага болсон байна. Eco bubble буюу хөөсөөр угаах технологид суурилсан бүрэн автомат угаалгын машин нь ус болон цахилгааны зарцуулалтыг улам багасгасан юм.

Худалдан авагчдын хувьд угаалгын машин авахдаа анхаарах ёстой нэг гол асуудал нь хэрэглэгчид өөрийн хэрэгцээнээс давсан багтаамжтай угаалгын машин авч бүрэн хүчин чадлаар нь ашигладаггүйд оршдог. Тухайлбал, бүрэн автомат угаалгын машин нь долоо хоногт хэр зэрэг цахилгаан болон ус ашигладаг вэ гэсэн наад захын тооцооллыг харахад 2-3 ам бүлтэй айл долоо хоногт хоёр удаа хэрэглэдэг угаалгын машиндаа 3,5 квт эрчим хүч зарцуулж, дунджаар 230 л ус зарцуулдаг байна. Өөрийн хэрэглээнээс илүү их багтаамжтай угаалгын машин хэрэглэх нь илүү их эрчим хүч зарцуулахаас гадна усыг байх ёстой хэрэглээнээс есөн хувиар илүү хэрэглэдэг бөгөөд угаалгын машиныг ашиглаагүй үед standby mode дээр байлгахгүйгээр цахилгаанаас бүрэн салгаснаар эрчим хүчийг 4-5 хувь хэмнэх боломжтой. Харин дөрвөн ам бүлтэй өрх угаах хувцасны материал болон өнгөнөөс хамааран долоо хоногт 2-3 удаагийн угаалтдаа 6 кг–ын угаалгын машин ашиглавал илүү хэмнэлттэй гэсэн судалгаа байдаг. Иймээс 6 кг-тай угаалгын машин нь хамгийн зөв сонголт болж байна. Сүүлийн үеийн угаалгын машинд түргэн угаалгын горим нэмэгдсэн бөгөөд тухайн горимд хамгийн ихдээ 2.5 кг хувцас угаах боломжтой юм.

Мөн түүнчлэн угаалгын нунтагийн зөв хэрэглээ нь хэрэглэгчдийн хувьд асуудал үүсгэж байдаг. Та бүрэн автомат угаалгын машин ашиглаж байгаа бол заавал бүрэн автомат угаалгын машинд зориулсан угаалгын нунтаг хэрэглэх нь тохиромжтойн дээр энэ нь таны сэтгэлд нийцсэн чанартай угаасан хувцас өмсөх үндэс болно.

Угаалгын машин ашиглахдаа хэрэглэгчид хувцасны жин болон угаалгын нунтагийн хэмжээгээ тааруулж чаддаггүй ажээ. Иймд угаалгын машин үйлдвэрлэгч компаниудын угаалгын машины технологид хийсэн хамгийн сүүлийн үеийн шинэчлэл нь I dousing технологи юм. Энэхүү технологийг ашиглан үйлдвэрлэсэн угаалгын машин нь угаах гэж байгаа зүйлийн жинг автоматаар тохируулахын зэрэгцээ тухайн угаах гэж байгаа зүйлийн жинд тааруулан угаалгын нунтаг болон зайлагчийг мөн автоматаар тохируулан угаадаг. Түүнчлэн та ухаалаг гар утсан дээрээ угаалгын машинаа удирддаг аппликайшин суулгаснаар гэртээ байхгүй байх үедээ ч угаалгын машинаа ажиллуулж, хувцсаа угаах боломжтой. Ийнхүү алсаас, гар утсаараа удирдан ажиллуулснаар угаалгын машин тань таныг эзгүй байх үеэр таны хувцсыг угаагаад, хатаагаад бэлэн болгоно.

Хэрвээ та шинээр угаалгын машин худалдан авах гэж байгаа бол брэндийн нэр хүнд гэхээсээ илүү өөрийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, технологийн дэвшилтэт угаалгын машин сонгох нь танд илүү их хэмнэлтийг авчрах болно.

ОНЦЛОХ ХУУДАС

Speak out

ДОЛЛАРЫН ХАНШ ӨСЧ НАЙМААЧИД ЭРГЭЛТГҮЙ БОЛЖЭЭ

Н.БАТЗАЯА

Сүүлийн хэдэн сар долларын ханш эрчимтэй өсөх болсон. Үүнээс болж бараа бүтээгдэхүүний үнэ өслөө гэх хандлага иргэдийн дунд гарсан билээ. Тиймээс жижиг дунд бизнес эрхлэгчидтэй уулзаж, долларын өсөлт бизнес эрхлэгчдэд хэрхэн нөлөөлж буй талаар "Speak out" бэлтгэлээ.

Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Ц.Минсэл: Иргэдийн худалдан авалт буурсан

/Машины сэлбэгийн худалдагч/

-Манайх Ланд-80, 200 машины сэлбэг зардаг. Би хүний лангуун дээр зогсож, худалдагч хийдэг. Сүүлийн жилүүдэд иргэдийн худалдан авалт буурсан нь эрс мэдрэгдэж байгаа. Өдөрт зардаг сэлбэгийн тоо ч буурах болсон. Яах вэ, өвөл болохоор авто машины худалдан авалт буурдаг л даа. Өвлийн улиралд хүмүүс аялал зугаалганд явдаггүй учраас буурчихдаг юм. Цагаан сарын дараа гайгүй болж эхэлдэг. Гэхдээ өмнөх жилүүдийнхтэй харьцуулахад автомашины сэлбэг худалдан авах иргэдийн тоо буурсан нь эрс ажиглагдаж байна. Энэ нь бараа бүтээгдэхүүний үнэ өссөнтэй холбоотой. Бараа бүтээгдэхүүний үнэ яагаад өсч байгаа нь ойлгомжтой шүү дээ. Долларын ханш өссөнтэй шууд холбоотой. Машины сэлбэг ч ялгаагүй дагаад өссөн. Манай энэ хавийнхан үнээ өсгөлөө гэж байна билээ. Манайх бол үнээ өсгөөгүй. Иргэд үнээ нэмээгүй байхад авч чадахгүй байгаа юм чинь нэмчихвэл бүр ч авахгүй шүү дээ. Гэхдээ зарим наймаачид үнээ нэмээд ч болтугай ганц, хоёр сэлбэг хэрэгсэл зараад дараагийн эргэлтээ бодож байгаа байх.

Г.Насанжаргал: Наймдугаар сараас хойш бараагаа татсангүй

/Хувиараа бизнес эрхлэгч/

-Долларын ханшийн өсөлт бидэнд нөлөөлөлгүй яах вэ дээ. Валютын урсгал л юм чинь. Бидний хувьд бараа таталт, эргэлт гэдэг зүйл зогсоод удаж байна. Аль 7, 8 дугаар сард зогссон. Манайх л гэхэд наймдугаар сараас хойш бараагаа татсангүй. Үнэхээр шаардлагатай гэвэл захиалгын яаралтай барааг л авч байгаа. Түүнээс биш сардаа нэг бараа татаад л ашгаараа дахиад явдаг үе өнгөрсөн. Бараг мартагдаж байна шүү дээ. Амьдралаа залгуулах гэж яваа бидэнд долларын ханш өсөлт их хүндээр тусч байна. Долларын үнэ өсчихөөр цаанаас бараа оруулж ирэхэд үнэтэй байгаа юм. Цаад зарж байгаа хүмүүс нь үнээ нэмчихээр бидэнд хэцүү. Ашиг ордлого бага хэрнээ хэт үнэтэй бараанд яваад байх хэцүү шүү дээ. Яах вэ зарим хүмүүс хаа байсан американийн мөнгөн тэмдэгт бидэнд ямар хамаатай юм бэ гэж бодож байж магадгүй. Өнөөдөр доллар бүх зүйлд хамааралтай болсон байна. Дэлхийн ихэнх улсад нөлөөгөө үзүүлж байна. Хятадын юанийн ханш хүртэл өсчихлөө. Эдийн засгийн хямралтай үед долларын ханш өсөөд байхаар чинь барааны үнэ нэмэгдээд байна. Барааныхаа үнийг нэмчихээр иргэд нь худалдаж авч дийлэхгүй. Ийм л нөхцөлд амьдарч байна. Одоо гарсан засгийн газар ч гэсэн энд анхаарах хэрэгтэй. Иргэдийн амьдрал өдөр бүр доройтож, ядуурал ихэсч байна гэдэг. Тэгвэл тэр чинь долларын ханшийн өсөлттэй л холбоотой гэдгийг ойлгомоор байгаа юм. Монгол мөнгө үнэгүй болчихоод байна. Монголын нэг төгрөг эх орондоо ч, гадаадад ч үнэгүй байна. Манай улсад нэг төгрөгөөр, за бүр болъё 20 төгрөгөөр юу худалдаж авч болох вэ. 100 төгрөгөөр юу авч хүрэх вэ. 100 төгрөгийн бохь гэж л байхаа больчихсон байна. Ийм байхад иргэд мянга ажил, хөдөлмөр хийгээд нэмэр алга. Цалин бага. Орон сууц нь тэнгэрт тулсан өндөр үнэтэй. Залуучуудаа дэмжинэ гээд л байдаг. Үнэндээ энэ бүхэн шал худал зүйлс. Үргэлж л худал ярьдаг. Залуучуудаа үнэхээр дэмжмээр байгаа бол монгол төгрөгөө дэлхийн зах зээлд үнэд хүргэ л дээ. Тэгж байж бидний цалин гэж авдаг хэдэн төгрөг юм болно. Тэгэхгүй долларт дарлуулсан хэвээрээ л байх юм бол залуусаа дэмжинэ гэж мянга яриад хэрэггүй. Үүнд наймаа эрхлэгчид ч ялгаагүй адилхан өртөж байна.

Ч.Нарантуяа: Нэг ширхэг өндөг хүртэл 20-30 төгрөгөөр нэмэгдсэн

-Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ өдөр ирэх тусам нэмэгдэж байна. Долларын ханш өссөн нь хувиараа жижиг бизнес эрхэлдэг бидэн шиг хүмүүст маш хүнд тусч байгаа. Ерөөсөө жижиг гэхгүй барааны үнэ нэмэгдлээ. Жишээлбэл, нэг ширхэг өндөг хүртэл 20-30 төгрөгөөр нэмэгдсэн шүү дээ. Талхны үнэ ч гэсэн дагаад нэмэгдсэн. Яах вэ, манай том үйлдвэрүүд үнээ гайгүй барьж байгаа л даа. Гэхдээ л "Талх чихэр" компанийн үйлдвэрлэдэг талхны үнэ нэмэгдсэн. Гаднаас импортоор орж ирдэг өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ бүгд өссөн. Элсэн чихэрний үнэ хүртэл нэмэгдлээ. Үүнийг дагаад иргэдийн худалдан авалт ч багассан. Өнгөрсөн жилтэй харьцуулахад иргэдийн худалдан авалт 50 хувиар буурсан. Энэ нь бидэнд маш муу нөлөө үзүүлж байна. Худалдан авагчид байхгүй бол наймаачид бид яаж бизнесээ эрхлэх билээ. Импортоор оруулж ирдэг барааны тоо ширхэг хүртэл дагаад буурчихаж байгаа юм чинь яаж ашиг олох вэ дээ. Сүүлийн үед иргэд дэлгүүр гэхээс илүү томоохон зах, бөөний худалдааны төвүүд рүү явдаг болсон байна. Ер нь бөөний дэлгүүрт ялгаагүй л үнэтэй байгаа. Биднийг бодвол 100-200 төгрөгийн л хямд үнээр зардаг. Иргэд өргөн хэрэглээний барааны үнэ өсөөд өөрсдөө ч мөнгөгүй болчихоороо аль хямд газар руу л явцгааж байна. Түүнээс болж жижиг дэлгүүрүүд үйлчлүүлэгчдээ алдах, үйлчлүүлэгчдийн тоо цөөрөх болсон. долларын ханш иргэдийн амьдралд шууд нөлөөлж байгааг төр засаг анхаарч үзээсэй гэж хүсмээр байна. Манай улс ихэнх бараа бүтээгдэхүүнээ гадаадын улс орноос импортоор авдаг болохоор доллар, юанийн өсөлт бидэнд ингэж нөлөөлж байгаа юм. Бизнес гэлтгүй ар гэрт хүртэл нөлөөлж байна. Манайх өмнө нь сард нэг удаа гэр бүлээрээ суугаад ресторанд ордог байсан. Одоо юун тэгэх. Оруулж ирсэн бараагаа ч зарж чадахгүй алдангид орчихоод л сууж байна. Шинэ Засгийн газартай болсон. Болохгүй, бүтэхгүй гээд суугаад байхын оронд аль болох иргэдийнхээ асуудлыг шийдвэрлэхийн төлөө ажиллаасай л гэж бодож байна.

Д.Эрдэнэчимэг: Долларын ханш өссөн гээд хятадууд ч гэсэн барааныхаа үнийг нэмлээ

-Нөлөөлөлгүй яах вэ. Бидэнд хамгийн ихээр нөлөөлж байгаа. Би хувиараа хөшиг зардаг. Өмнө нь орлого ихтэй учраас бараагаа хурдан эргэлтэд оруулдаг байлаа. Сая сүүлийн хэдэн сар долларын ханш огцом өссөн гээд эргэлтэд оруулж чадахгүй байна. Хүмүүс ч хөшиг худалдаж авахгүй юм. Би Хятадаас бараагаа татдаг. Доллар өссөн гээд хятадууд ч гэсэн барааныхаа үнийг нэмлээ. Юанийн ханш нь ч өссөн. Худалдан авалт байхгүй болохоор л бид бараандаа явж чадахаа больчихож байгаа юм. Хүмүүс бие биетэйгээ харилцан хамааралтай амьдардаг гэдэг нь эндээс харагдаж байгаа юм л даа. Улс орны эдийн засаг хямарсан гэж байна. Үүнээс болж олон хүн ажлаасаа халагдаж, олон байгууллага цалингаа тавьж чадахгүй байгаа юм. Ажилгүй, цалингүй иргэд худалдан авалт хийж чадахгүй шүү дээ. Иргэд юм худалдаж авахгүй болохоор бид орлогогүй болчихдог. Орлогогүй байж үнэтэй бараа оруулж ирэх хэцүү. Ингээд л дам дамандаа л нэг нэгнээсээ хамааралтай амьдардаг. Өөрөөр хэлбэл, долларын ханшийн өсөлт бидэнд ч иргэдэд ч нөлөөлж байна гэсэн үг. Би хамгийн сүүлд өнгөрсөн есдүгээр сард бараандаа явж ирсэн. Түүнээс хойш одоо болтол яваагүй. Уг нь одоо явах хугацаа нь болсон л доо. Худалдан авалт, орлого байхгүй болохоор явж чадахгүй байна. Бид ганцхан бараа татаад амьдрах биш. Энэ лангууг хүртэл түрээслэж суудаг. Тийм болохоор лангууныхаа түрээсийг өгөхөөс эхлээд асуудал их гарна. Дээр нь худалдан авагч багасчихаар бүр хэцүү л дээ. Өмнө нь хүмүүс зүгээр үзэж явж байгаад өөрт нь таалагдвал "За гэрийнхээ хөшгийг сольё. Манайх ч одоо солихоор болсон шүү" гээд авчихдаг байсан. Одоо бол үнэхээр шаардлагатай, зорьсон хүмүүс л ирж авдаг. Энд чинь би ганцаархнаа хөшиг зараад суугаагүй. Олон хүн бий. Тэгэхээр өдөрт хөшиг авах 10 хүн байлаа гэхэд над дээр нэг нь ирэх үү, үгүй гэдэг л болж байгаа юм. Долларын ханшинд дарлуулаад л амьдарч байна даа. Эргэлтээ хийж чадахгүй байгаа юм чинь дарлуулснаас өөрцгүй биз дээ.

ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

Дэлхийд өрсөлдөхүйц

Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Төгсгөл.
Түрүүч нь I нүүрт

Энэ бүхэн хэний ч өмнө хүүхдийнхээ нүүрийг улайлгахгүй гэх эцэг, эхчүүдийн зовнил басхүү улсын нэр хүндтэй сургуульд сурч л байвал боллоо гэсэн залуусын харалган бодолтой холбоотой. Гэхдээ улс, орон хөгжихийн хэрээр иргэдийн сэтгэлгээ ч өөрчлөгджээ. Тэд хаана ч очсон өөрийн чадвараар санхүүгийнхаа эс үүсвэрийг олж чадахуйц мэргэжлийг илүүд үзэх болж. Өөрөөр хэлбэл, залуус ур чадвартай мэргэжлийн боловсон хүчин бэлтгэдэг коллежуудыг сонгон суралцаж байна. Тиймээс "Монголын мэдээ" сонин мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэдэг коллежууд дундаа үлгэр жишээ болохуйц загвар коллеж гэгддэг Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэр, Урлалын Политехник коллежоос энэ удаагийн "Дугаарын сурвалжлага"-аа бэлтгэлээ.

Материаллаг бааз хангалттай учраас сурагчид хичээлдээ дуртай байдаг

Үзэсгэлэнт гүнж, эрт үеийн хаад, эрэлхэг баатар, хурдан хүлэг, эрээн цэцэг гээд сурагчдын урласан сийлбэр, зурсан зураг, баримлыг сургуулийн коридортоо дэлгэгдсэн байх нь ёстой л Үйлдвэрлэл, урлалын полетихникийн коллеж гэдгийг жинхэнэ утгаар нь илтгэж байв. Энэ мэт уран баримал, зураг, сийлбэр хосолсон урт коридороор явсаар оёдлын анги руу оров. Ангийн ханыг тойруулан 15 орчим оёдлын машин байрлуулсан байх бөгөөд оёдлын ангийн хоёрдугаар курсийнхний мэргэжлийн хичээл ид орж байлаа. "Оёдлын машины ард яаж суухаа ч мэдэхгүй орж ирсэн намайг багш нар минь өдий

МОНГОЛ УР ЧАДВАРТАНГ

..."Бидний сургалтын агуулга бол ур чадвартай сайн мэргэжилтэй ажилтан бэлтгэх. Гэхдээ бид энэхүү сургалтын агуулгатайгаа уялдуулан тухайн сурагчийн зөв төлөвшилд анхаарч байна. Өөрөөр хэлбэл, мэргэжилдээ үнэнч, сэтгэлтэй, зөв төлөвшилтэй мэргэжлийн боловсон хүчинг бэлтгэн гаргахыг зорьдог...

Багшийн ёс зүй, сурагчийн төлөвшилд анхаарч ажиллана

Манай сурвалжлах хэсэг өглөөний 10:00 цагтай уралдан тус коллежийг зорьсон юм. Биднийг очиход аль хэдийнэ хичээлийн цаг эхэлж, сургуулийн коридорт нам гүм байдал ноёрхсон байв. Сургуулийнхаа мэдээлийн самбарт "Хөдөлмөр зах зээлийн эрэлт, ажил олгогчдын шаардлагад нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэнэ" хэмээх эрхэм зорилгоо хүндэтгэн байршуулсан тус коллеж анх 1966 онд Нийтийн аж ахуйн үйлчилгээний техник мэргэжлийн сургууль нэртэйгээр байгуулагдаж эдүгээ 50 дахь жилтэйгээ золгожээ. Түүнээс хойш нийтлэг үйлчилгээний чиглэлийн мэргэжилтэй ажилтан бэлтгэсээр ирсэн байна. Харин Монгол Улсын Засгийн газрын 1995 оны арваннэгдүгээр сарын 3-ны өдрийн 197 дугаар тогтоолоор БНЭУ-ын төр нийгмийн зүтгэлтэн Ерөнхий сайд асан Ражив Гандийн нэрэмжит болсон түүхтэй. Түүний дараа 2012 онд одоогийн нэршлээ авч, Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл Урлалын Политехникийн коллеж болсон байна. Тус коллеж нь 2011 онд хоёр дахь удаагаа магадлан итгэмжлэгдсэн төрийн өмчийн сургууль гэдгийг энд онцолъё. Бид юун түрүүнд тус сургуулийн захирал Б.Даваажав, сургалтын албаны менежер Г.Баярхүү нартай уулзаж, сургуулийн талаархи халуун яриа өрнүүлсэн юм. Б.Даваажав захирал бидэнд энэ хичээлийн жилд багшийн ёс зүй, харьцааны соёл, хандлага хариуцлагыг дээшлүүлж, зөв төлөвшилтэй, мэргэжилдээ сэтгэлтэй, ур чадвартай мэргэжилтэн бэлтгэх зорилт тавин ажиллаж буйгаа танилцуулсан. Багшийн ёс зүй, сурагчийн төлөвшлийг чухалчлах болсон нь учиртай аж. Мэргэжилтэй ажилтанд сайн ур чадвараас гадна төлөвшил хамгийн чухал байдаг аж. Энэ тухай тэрбээр "Бидний сургалтын агуулга бол ур чадвартай сайн мэргэжилтэй ажилтан бэлтгэх. Гэхдээ бид энэхүү сургалтын агуулгатайгаа уялдуулан тухайн сурагчийн зөв төлөвшилд анхаарч байна. Өөрөөр хэлбэл, мэргэжилдээ үнэнч, сэтгэлтэй, зөв төлөвшилтэй мэргэжлийн боловсон хүчинг бэлтгэн гаргахыг зорьдог. Тухайн ажилтан сайн, ур чадвартай байлаа ч эрхэлсэн ажилдаа үнэнч биш байвал тэр хүнээс ур бүтээл бага гарна. Харин эрхэлсэн ажилдаа үнэнч, сэтгэлээсээ ханддаг байвал ажлын ур бүтээмж ч сайжирна. Тиймээс бид багшийн ёс зүй, сурагчийн зөв төлөвшлийг гол зорилго болгон ажиллаж байна" гэв. Түүнтэй ярилцаж байхдаа энэхүү зорилгыг тавих нь ч зүйн хэрэг хэмээн бодож байсныа нуух юун. Учир нь тус сургуульд суралцагчдын дийлэнх хувь нь 14-15 насны хүүхдүүд байдаг. Сурагчийн ширээнээс тохой мулталж ч амжаагүй өсвөр насны хүүхдүүд амьдрал, ажил мэргэжлийнхээ чиг баримжааг энэ коллежоос авахаар сонгон суралцаж буй. Тиймээс эдгээр хүүхдүүдэд мэргэжлийн ур чадвараас гадна зөв хүн болж төлөвших, аливаа асуудалд зөвөөр хандаж, үнэнч шударга байдлыг эрхэмлэх ухаанд сургах нь зүйн хэрэг. Энэ нь ч сургалтын ажлыг бүрэн гүйцэд хийж байна гэсэн үг. Манай улсад мэргэжлийн ур чадвартай ажилтан бэлтгэдэг төрийн өмчийн 37 коллеж үйл ажиллагаа явуулдаг. Нэгэн чиглэлд үйл ажиллагаа явуулж буй бусад коллежуудаас ялгарах нэгэн онцлог нь энэ ажээ. Ийнхүү ярилцсаны дараа сургалтын албаны менежер Г.Баярхүү сургуулиа бидэнд танилцуулсан юм.

зэрэгт хүргэсэн" хэмээн ярих охиныг А.Мөнхжин гэдэг. Одоо оёдлын ангийн хоёрдугаар курст сурдаг байна. Тэрбээр "Би багаасаа оёдолчин болохыг хүсдэг байлаа. Тийм болохоор Үйлдвэрлэл урлалын политехникийн коллежийг сонгосон. Нэгдүгээр курст орохдоо зүүгээ ч зөв сүвлэж чаддаггүй, ёстой оёдлын талаар "А" ч байхгүй л байсан. Нэгдүгээр курсдээ зах, халаас, зангилаа хийж сурсан. Одоо бол цамц, өмд, юбка оёж чадна. Удахгүй гадуур хувцас оёж сурна. Энэ бүхэн багш нарын маань ач. Хүүхэд бүртэй тулж ажилладаг" гэв. Энд хүүхэд бүр нэг оёдлын машин дээр ажиллах аж. Хэн нэгэнд нь хүрэлцэхгүй, нэг нэгнээ хүлээнэ гэсэн ойлголт байхгүй. Сургалтад хэрэглэгдэх материаллаг бааз хангалттай учраас сурагч хичээлээс хоцрох, хичээлээ ойлгохгүй байх зэрэг асуудал гардаггүй байна. Мөн багш сурагч бүртэй харилцах боломж нээлттэй байдаг ажээ. Бидний дараагийн орсон анги бол мөн л оёдлын нэгдүгээр курсийнхэн. Хүүхэд бүр урдаа цаас, нимгэн хөөсөнцөр тавьчихсан элдэв янзын дүрс хайчилж, нааж байлаа. Этгээд чамин хийцтэй энэ бүтээлийг шууд хараад ойлгох ч ямар утга учиртай, юунд ашигладгийг нь мэдэх боломжгүй. Харин сурагчдын урлаж буй элдэв сонин хайчилбар нь Дүрсний зохиомжийн хичээл гэдгийг багш нь бидэнд тайлбарласан юм. Өөрөөр хэлбэл, хувцас зохион бүтээхийн үндэс суурь нь дүрсний зохиомжийн хичээл аж. Энэ талаар Хувцас дизайны багш М.Энхтуяа "Хувцас дизайны ангиуд дүрсний зохиомжийн хичээлийг судлах зайлшгүй шаардлагатай. Энэ хичээлийг орсноор хувцасны ерөнхий зохиомжийг гаргаж сурдаг. Тэгэхээр маш чухал хичээл. Хувцас дизайны мэргэжлээр суралцаж буй хүүхдүүдийн маш

Ашигт малтмалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт заасны дагуу тусгай хэрэгцээнд байлгах хугацаа дуусан, тусгай хэрэгцээний газрын мэдээлэл

№	Тусгай хэрэгцээнд бүртгэгдсэн код	Талбайн нэр	Зориулалт	Талбай (га)	Тогтоолын дугаар	Шийдвэрийн огноо	Дуусах огноо	Захиргааны нэгж	Шийдвэрлэсэн
1	SRA-01233	Балгас голын Улаан нуур орчим	Ерөнхий тусгай хэрэгцээний газар	101,144.76	7/8	2010.12.24	2015.12.24	Аймаг/хот	Өмнөговь
2	SRA-01975	Тахилгат овоо Хайлааст	Байгалийн нөөцөд авсан газар	17,635.09	А/04	2016.03.17	2016.03.17	Сум/дүүрэг	Мөрөн
3	SRA-01154	Баруун цогт	Отрын бүс	26,254.60	09	2011.03.29	2016.03.29	Аймаг/хот	Сүхбаатар
4	SRA-01155	Бүрэн цогт	Отрын бүс	2,910.71	09	2011.03.29	2016.03.29	Аймаг/хот	Сүхбаатар
5	SRA-01156	Заан ширээ	Отрын бүс	27,285.47	09	2011.03.29	2016.03.29	Аймаг/хот	Сүхбаатар
6	SRA-01157	Халзан овоо	Отрын бүс	17,996.87	09	2011.03.29	2016.03.29	Аймаг/хот	Сүхбаатар
7	SRA-01158	Тунгаан говь, Улаан нуур, Хар нуур	Отрын бүс	19,263.66	09	2011.03.29	2016.03.29	Аймаг/хот	Сүхбаатар

КАДАСТРЫН ХЭЛТЭС

ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

сайн судлах ёстой хичээлийн нэг” гэв. Энэ ангид бас нэгэн анхаарал татсан зүйл байсан маникенд өмсүүлсэн монгол загварын хувцаснууд. Эрхэмсэг, ихэмсэг нэгнийг илтгэх эдгээр хаад, хатдын дээлийг тус сургуулийн багш, сурагчид хамтран 50 жилийн ойн баяртаа зориулан урлажээ. Нийт 50 орчим дээлээс бүтэх уг коллекцийг гаргахад оёдлын чиглэлээр суралцдаг бүх оюутнууд оролцсон аж. Тухайлбал, нэгдүгээр курсийн оюутнууд нь шүр сувд хатгах, чимэглэл, гар урлалын тал дээр ажилласан бол хоёрдугаар курсийн охид оёх тал дээр ажилласан байна. “Хаадын жавхаа” хэмээх энэхүү коллекцийг тус сургуулийн долоон багш оюутнуудтайгаа хамтран гаргасан аж.



Сурагчид хичээлдээ үйлдвэрийн технологийг ашигладаг гэв

Манай сурвалжлах хэсэг ийнхүү сургуулийн орчинтой танилцаж явтал аль хэдийнэ хүүхдүүдийн хичээл завсарлажээ. Энд тэндгүй сонирхолтой яриа өрнүүлсэн сурагчид явах нь аргагүй л хүүхэд насны занг илтгэнэ. Анх Үйлдвэрлэл, урлалын политехникийн коллежид орж ирсэн цагаас анзаарагдсан нэг зүйл гэвэл сурагчдын хичээлдээ ашигладаг материаллаг бааз. Үүнийг батлах гэсэн шиг дараагийн орсон анги маань хүртэл хичээлдээ ашигладаг хэрэглэгдэхүүнээрээ ангиа дүүргэжээ. Ингээд хэлэхэд нэг их хилсдэхгүй. Үнэхээр л ангийн үүднээс эхлээд л мэргэжлийн багаж, төхөөрөмж байхад сурагчид хичээлдээ чармайлгүй гээд ч яах билээ. Бидний орсон энэ танхим бол Мехатроникчийн анги байсан юм. Тус ангид л гэхэд манай улсын томоохон үйлдвэрүүдэд ашигладаг сүүлийн үеийн тоног төхөөрөмжүүдийг байрлуулжээ. Гэхдээ сургалтын гэдгийг энд онцолъё. Өөрөөр хэлбэл, тухайн төрөөмжийг сургалтад ашиглах зориулалтаар мэргэжлийн боловсон хүчин бэлтгэгдэж байгаа нь мэдрэгдэж байлаа. Монголын мэргэжилтэй боловсон хүчинг яаж бэлтгэдэг, сурах орчинг хэрхэн бүрдүүлдэг, багш нь сурагчидтайгаа хэрхэн харьцдаг вэ гэдгийг тус коллежийн үйл ажиллагаатай танилцаж байхдаа л мэдэрсэн. Багш нартай хамтран уран бүтээл, загварын үзэсгэлэн гаргадаг мэргэжлийн коллежууд ховорхон. Тэр дундаа тухайн хүүхдийн төлөвшилд анхаарч, сургуулийнхаа хичээлийн жилийн зорилго болгох коллеж байхгүй гэхэд хилсдэхгүй биз. Одоо үйл ажиллагаа явуулж буй ихэнх коллежууд заагдсан хугацаанд мэргэжлийн мэдлэг, мэдээллээ л сурагчид олгохыг эрхэмлэдэг.

“ҮЙЛДВЭРЛЭДЭГ” КОЛЛЕЖ

жижигрүүлсэн аж. Хичээлд ашигладаг багаж, төхөөрөмжүүд хичээлийг нь сонирхолтой болгодог тухай ч тус ангийн сурагчид хэлж байв. Тус сургууль сүүлийн жилүүдэд сургалтын орчноо сайжруулах, сургалтад ашиглагдах тоног төхөөрөмжийг сайжруулах тал дээр олон ажил хийсэн нь энэ аж. Тодруулбал, Бүгд найрамдах Энэтхэг улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар 10, МСС-ийн төслөөр тав, Японы “ЖАЙКА” олон улсын байгууллагын төслөөр үсчин, гоо заслын төрөлжсөн таван дадлагын газрыг шинэчлэн байгуулжээ.

300 хүүхдийн дотуур байрыг бэлтгэжээ

Сурагчдын сурах бололцоог хангасан нэг ажил нь дотуур байр. Тус сургуульд хөдөө, орон нутгаас ирж суралцах хүүхдүүд олон байдаг гэнэ. Тиймээс тэр хүүхдүүдэд зориулж 300 хүүхдийн дотуур байрыг байгуулжээ. Манай сурвалжлах хэсгийг сургуультай танилцаж байх үеэр дотуур байранд суудаг гэх хүүхдүүд ч таарч байлаа. Тэдний нэг нь Т.Цэрэннадмид охин. Т.Цэрэннадмид Дундговь аймгаас ирж, гоо засалч мэргэжлийн нэг жилийн ангид суралцаж байгаа гэнэ. Тэрбээр “Би сургуульдаа байх их дуртай. Яг мэргэжлийн багаж хэрэгсэл дээр ажиллах хамгийн гоё байдаг. Өглөө 08:00 цагт сургууль дээрээ ирээд орой 18:00 цагт дотуур байр руугаа явдаг. Манай сургуулийн дотуур байр их тохитой. Энэ сургуулийг сонгох болсон нэг шалтгаан нь дотуур байр байсан. Надад хотод суух айл байгаагүй. Тиймээс дотуур байртай, гоо сайханч мэргэжлээр элсэлт авдаг сургууль хайж байсан” гэв. Энэ мэтчилэн хөдөө, орон нутгаас элсэгчид ирж, тус сургуулийг сонгон суралцдаг байна. Түүнээс гадна сурагчдын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөхөд зориулж номын сан, биеийн тамирын заал, талбай, хичээлээс гадуурх секц сонгон хичээллүүлдэг ажээ. Ражив Гандийн хэмээн овоглох төрийн өмчийн энэхүү коллеж нийт гурван тэнхимд 78 багш ажилладаг. Сургуулийн захиргаанаас багш нарыг чадавхижуулах ажлыг шат дараатайгаар зохион байгуулдаг байна. Тодруулбал, өнгөрсөн жил гэхэд БНЭУ-д англи хэлний сургалтадгурванбагш,электроник мехатроникийн дөрвөн багш, гагнуурын мэргэжлээр хоёр багш, цахилгааны мэргэжлээр хоёр багш, БНСУ-д оёдлын таван багш, Малайз улсад автын нэг багшийг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулжээ. Харин энэ жилийн хичээлийн зорилгодоо уялдуулан багшийн ёс зүйг хөгжүүлэхэд түлхүү анхаарч ажиллаж байгаа бөгөөд захирал Б.Даваажав “Сурагчдын толь нь багш нар байдаг. Хүүхэд анги даасан багшаа л дуурайдаг. Тийм учраас багш хүний ёс зүй маш чухал. Хүүхдүүдэд багш нарын үлгэр дуурайлал их чухал байдаг. Бид хүүхдүүдэд зөв төлөвшил олгохыг зорилго болгож байгаа юм чинь багш нарт ч ёс зүйг сургах хэрэгтэй. Ёс зүйтэй багш сурагчдад зөв төлөвшлийг олгоно шүү дээ. Тиймээс багш нарыг ёс зүйтэй байлгах тал дээр анхаарч ажиллах болно” гэв.

Сурагчдынх нь ур чадвар дэлхийн хэмжээнд хүрчээ

Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл, урлалын политехникийн коллеж гэх нэр олон тэмцээн, уралдаан, үйл ажиллагаанд дурьдагддаг. Тэр дундаа ур чадвартай боловсон хүчин бэлтгэдэг коллежууд дундаа загвар сургууль болж, аливаа үйл ажиллагаанд оролцдог. Тэр бүү хэл багш, сурагчид нийлж үзэсгэлэнгээ дэлгэлээ гэсэн мэдээлэл гарахад л Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл, урлалын политехникийн коллеж байдаг. Өнгөрсөн жил гэхэд тус сургуулийн үсчин, гоо сайханчийн ангийн оюутнууд “Дэлхийн ур чадварын олимп”-д эх орноо төлөөлөнамжилттай оролцсон. Энэ мэтчилэн тус сургуулийн сурагчдын гаргасан амжилт олон. Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Хаврын гоёл-2011, 2012, 2014 онд тэргүүн байр, “Ур чадвар-2013” оёдлын мэргэжлийн улсын уралдааны тэргүүн байр, “Ур чадвар-2016” оёдлын мэргэжлийн улсын уралдааны дэд байр, Мэргэжлийн сургуулиудын Монгол хэлний олимпиадын тэргүүн байранд 2012-2015 онд шалгарч байжээ. Сурагчдын гаргасан амжилт тус коллежийг аль хэдийнэ дэлхийн хэмжээнд өрсөлдөхүйц мэргэжилтэн бэлтгэж буйг илтгэж байв. Энэ үеэр сургалтын албаны менежер Г.Баярхүү сургалтын бааз, хэрэглэгдэхүүн хангалттай учраас сурагчид ямар ч асуудал гардаггүй гэдгийг онцолсон.

Ямартай ч, тус сургуулийн үйл ажиллагаатай танилцахад ийм байна. Дэлхийн хэмжээнд өрсөлдөхүйц ур чадвартай Түүнээс тухайн хүүхдийн төлөвшилд анхаарал хандуулна гэдэг үлгэрийн далай гэж халаглах биз. Харин Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл, урлалын политехникийн коллежийнхон мэргэжилтэй ажилтан бэлтгэхээс гадна тухайн хүүхдийг бие хүн болон төлөвшихөд туслах арга барилыг эрхэм зорилгоо болгосон нь тус коллежоос суралцах хамгий эрхэм зүйлсийн нэг юм.



ЭМГЭНЭЛ

Бидний хайрт аав Цэрэнсодном овогтой Нямдорж 2016 оны арваннэгдүгээр сарын 13-ны өдөр хүнд өвчний улмаас таалал төгсч, бид бүхэнд нөхөж баршгүй гарз тохиолоо.

Хайрт аав Цэрэнсодном овогтой Нямдорж минь 1960 оны наймдугаар сарын 23-нд Цэрэнсодномын найман хүүхдийн хоёр дахь хүү болон мэндэлсэн. Бага насаа эцэг, эхийн гар дээр бойжин, цэцэрлэгээр хүмүүжсэн. 1968 онд нийслэлийн арван жилийн 24 дүгээр дунд сургуульд элсэн орж, төгссөн. 1978 онд Монгол Улсын Техникийн Их сургуулийн “Мод боловсруулах үйлдвэрийн Механик инженер”-ийн ангид элсэн орж, 1983 онд дүүргэсэн. Ц.Нямдорж нь сургууль төгсөөд ой модны яамны харьяа Мод боловсруулах үйлдвэр, мебель картоны үйлдвэрүүдэд тус тус механикийн инженер, мастер, цехийн дарга, үйлдвэрийн дарга зэрэг ажлуудыг хийж, ажиллах хугацаандаа ажилчин залуучуудыг зохион байгуулж удаа дараагийн 5 жилийн гавшгай хөдөлгөөнүүдийг амжилттай удирдан хот, улсын хөдөлмөрийн аваргуудыг, шилдэг инженерүүдийг төрүүлсэн гавьяатай билээ.

2000 онд Удирдлагын академийг төгсч мэргэжлийн дагуу нийслэлийн мэргэжлийн хяналтын газар ажиллаж мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, хэлтсийн даргын үүрэгт ажлыг нэр төртэй гүйцэтгэж ирсэн. Аавын минь улс, эх орондоо 40 гаруй жил ажилласан хөдөлмөр зүтгэлийг үнэлэн, Таван жилийн гавшгайч, Эвлэлийн төв хорооны “Хөдөлмөрийн алдар” алтан медаль, Улаанбаатар хотын тэргүүний ажилтан, Ой модны салбарын тэргүүний ажилтан, Ардын хувьгалын 80, 90 жилийн ойн медаль, төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн хүндэт медаль”, “Алтангадас” одонгоор шагнаж, урамшуулсан билээ.

Аав минь оюутан байх үедээ буюу 1980 онд бидний ээж Ишлувсангийн Цэрмаатай гэр бүл болон гурван хүүхэд төрүүлж, өсгөн дээд боловсрол эзэмшүүлэн эх орон, ард түмэндээ хэрэгтэй авьяаслаг, чадалтай эмч нарыг бэлтгэж, ах дүүдээ элгэмсэг тусч, аав ээждээ энэрэлтэй сайн хүмүүс болгон хүмүүжүүлсэн ачтан билээ.

Аавын маань ажил хэрэгч, ажилсаг хөдөлмөрч чанар, цэвэрч нямбай, хамт олондоо эелдэг, тусч чанарыг гэр бүл, үр хүүхэд, ач зээ, ах дүү, төрөл төрөгсөд, найз нөхөд нь үеийн үед санан дурсаж явах болно.

УМ САЙН АМГАЛАН БОЛТУГАЙ.

NO STRESS

ЯРИЛЦАХ ТАНХИМ

Д.Цэнгэл:

Кино урлагийг дэмжихгүй байна гэдэг маркетингүй компаниас ялгаагүй

Б.ДАВАА

"Тэнгис" кино театрын маркетингийн ахлах менежер Д.Цэнгэлтэй ярилцлаа.

-ОХУ-ын "Мөнгөн морь" кино наадамд "Ээж" кино тун амжилттай оролцсон. "Тэнгис" кино театр тус киноны дистрибьютерээр ажилласан шүү дээ. Кино наадмын сонин хачинаас манай уншигчдад хуваалцахгүй юу?

-Кино наадам бүр өөр өөрийн гэсэн онцлогтой. Уран сайхны болон богино хэмжээний, аймшгийн, фантастик гэх мэтээр ангилагддаг. Иймээс нэг кино бүхий л кино наадмуудад оролцох боломжтой гэж ойлговол өрөөсгөл болно. "Ээж" кино манай театрт өнгөрсөн зургадугаар сарын 6-нд нээлтээ хийсэн. Хэдийгээр наймдугаар сарын дунд үе хүртэл гарсан ч, амралт зугаалгын үе таарсан болохоор ч тэр үү, хүмүүст хүрч чадаагүй. Гэхдээ тус киног олон улсын наадамд явуулсны дараа мэдээлэл нь хүмүүст хүрч, киног үзэх хүсэлтэй иргэдийн тоо нэмэгдэж эхэлсэн. "Ээж" кино аравдугаар сарын 26-28-ны хооронд ОХУ-ын Уфа хотод болсон "Мөнгөн морь" кино наадамд уригдаж оролцсон юм. Тус кино наадамд Монголын анхны уран бүтээл оролцсон нь энэ байлаа. Шүүгчдийн зүгээс өндөр үнэлгээ авч, МУГЖ Ж.Мэндбаяр "Шилдэг эмэгтэй дүр"-ийн шагналыг хүртсэн. Олон улсын кино наадмаас нэр зааж, том шагнал хүртсэн тохиолдол нэлээд олон жилийн дараа тохиож буй нь энэ л дээ. Миний хувьд энэ удаагийн наадамд шүүгчээр бус, дистрибьютерийн үүргээр оролцсон.

-Тус наадмыг дуусгаад л, Дэлхийн Азийн кино наадамд "Ээж" киног сойсон гэж дуулсан юм байна?

-Тийм ээ. "Мөнгөн морь" наадмыг дуусгаад л дараагийн тэмцээн рүүгээ хөдөлсөн. АНУ-ын Лос Анжелес хотод Дэлхийн Азийн кино наадам зохион байгуулагдсан юм. Бид эхний наадмаа дуусгаад шууд л Лос-Анжелес руу нисч, нисэх онгоцны буудалд газардмагцаа л дараагийн тэмцээнээ зорьсон. Машиндаа хувцсаа солиод л кино театр руу орж, шүүгчдийн асуултад хариулж билээ. Тэнд байсан үзэгчид маш өндөр сэтгэгдэлтэй байсныг энд дурьдах хэрэгтэй. Энэ эмэгтэй жүжигчин Монголд алдартай юу, кино хэдий хэрийн хөрөнгөөр бүтсэн бэ, зураглаачийн ажил хэр байв гэх мэт асуултыг надаас сонирхон асууж байсан. Учир нь ийм хэмжээний кино бүтээхэд маш их хэмжээний хөрөнгө зарцуулагддаг юм. Гэтэл монголчууд нэг сар бэлтгэлээ хангаж, нэг сар зураг авалтаа хийгээд, үндсэндээ гурван сарын дотор л киногоо хийдэг. Тиймээс шүүгчид кино бүтсэн төсвийг сонсоод үнэхээр гайхаж байсан. "Та нарыг өндөр үзүүлэлт бүхий техник технологиор нь хангачихвал юуг ч хийж чадах авьяастай хүмүүс юм байна. Кино урлаг хөгжиж байгаа юм байна" гэж үнэлж байсан шүү.

-Кино урлаг хөгжиж байгаа. Гэхдээ манай зах зээл хэт жижиг. Ер нь кино театрыг зорих үзэгчдийн тоо хэр байна вэ?

-Монголын уран бүтээлчид жилдээ 30-40 кино хийдэг. Сард 3-4 кино нээлтээ хийж байна. Кино бүр харилцан адилгүй. Уран бүтээл, найруулагчийн чанар чансаа, тоглосон жүжигчдээсээ хамаараад дэлгэцнээ амьдрах чадвар нь ч янз бүр. Ихэвчлэн театрт гарсан кино 4-5 сарын дараа IPTV буюу бидний хэлж заншсанаар Univision, Skymedia, Ddish-ийн кино сангуудад тавигддаг. Монголын кино зах зээл маш жижиг. Жилдээ 3-4 уран бүтээл хийчихдэг хүн байхад, 2-3 жилдээ нэг даацтай бүтээл хийх уран бүтээлчид ч бий. Тэднийг дэмжиж, хийсэн уран бүтээлд нь зах зээлд оршин тогтнох боломжийг олгож, дэлхийн хэмжээнд хүргэхийн тулд олон улсын кино наадмуудад оролцуулах шаардлага бий. "Тэнгис" кино театрын хувьд Монголынхоо уран бүтээлчдээ илүүтэй дэмжихийг эрмэлздэг. Мөн Элчин сайдын яамдуудтай хамтран олон улсын соёлын өдрүүдийг зохион байгуулдаг. Жил бүр "Улаанбаатар" кино наадмыг Монголын Урлагийн зөвлөлтэй хамтран зохион байгуулж байна. Ирэх оны эхээр Японы соёлын өдрүүд "Тэнгис" кино театрт болно. Өмнө нь Франц, Солонгос, Турк, Колумбийн кино өдрүүдийг амжилттай зохион байгуулсан. Колумбийн кино өдрүүдийг БНСУ-д суух Элчин сайд нь Улаанбаатарт хүрэлцэн ирж, соёлоо сурталчилсан. Тэд кино өдөрлөгт ийм их ач холбогдол өгч байна. Кино бол тухайн соёлыг хүмүүст таниулах хамгийн чухал зэвсэг. Тиймдээ ч киногоор дамжуулан соёлоо сурталчилснаар бид бусад орны соёл, хүмүүсийг ойлгож, үнэт зүйлийг нь хүндэтгэдэг болж байна. Нөгөө талаар, хамтран ажиллах боломж нээгдэхээс гадна, нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой. Ний нуугүй хэлэхэд, гадаадын зарим улс оронд явж байхдаа манай Элчин сайдын яамд яагаад Монголынхоо уран бүтээлчдийн сор сор бүтээлүүдийг тухайн улс оронд гаргаж, түүх соёлоо түгээн дэлгэрүүлдэггүй юм бол гэж бодож, дотроо эмзэглэх үе байдаг.

> ...Монголын уран бүтээлчид жилдээ 30-40 кино хийдэг. Сард 3-4 кино нээлтээ хийж байна. Кино бүр харилцан адилгүй. Уран бүтээл, найруулагчийн чанар чансаа, тоглосон жүжигчдээсээ хамаараад дэлгэцнээ амьдрах чадвар нь ч янз бүр...

-Та үзэгчдийн кино театрт ирэх давтамж нэмэгдэж байгааг дээд дурьдсан. Магадгүй дахин дахин ирэх шалтгаан нь "Тэнгис" кино театрын зохион байгуулж буй үйл ажиллагаатай холбоотой байх?

-Кино театрт Холливудын мундаг бүтээлүүд байнга л гарч байдаг. Гэхдээ есдүгээр сард АНУ-ын Элчин сайдын яам, Монголын Урлагийн зөвлөл, манай кино теартын хамтран зохион байгуулсан Америк кино өдөрлөгийн үеэр маш өөр өнцөг харагдаж байсан. Тэдгээр киноноос тус орны бидний мэддэгээр өөр өнгө төрхийг харж болох байлаа. Мэдээж манайх бизнесийн байгууллага. Хамтран ажиллах тодорхой нөхцлүүд бий. Гэхдээ түүнээс илүүтэйгээр нийгэмд соёлоо түгээх, уран бүтээлчдийнхээ үзэл бодлыг гаргахын тулд дэмжиж, тодорхой үйл ажиллагаануудыг зохион байгуулдаг.

-Кино уран бүтээлчид бор зүрхээрээ л яваа гэдэгтэй та санал нийлэх үү. Үнэндээ кино урлагийг дэмжихэд төр засгаас төдийлөн анхаараад байдаггүй. Харин эсрэгээрээ кино театрууд нийгмийн хариуцлагынхаа хүрээнд энэ үүргийг хүлээж байна?

-Юуны түрүүнд урмын үг хайрласанд баярлалаа. Улс орон, төр засгийн хэмжээнд кино урлагаа дэмжихгүй байна гэдэг маркетингийн албагүй бизнесийн байгууллагаас ялгаагүй. Соёлоо сурталчилж, түгээн дэлгэрүүлж чадахгүй юм бол бидний юуг дэлхий нийт үнэлэх юм бэ. Лос-Анжелесийн Дэлхийн Азийн кино наадамд улс орны Соёлын сайд, Элчин сайдууд нь оролцдог юм билээ. Энэ бол кино урлагт ямар их анхаарч байгаагийн илрэл юм. Энэ дашрамд нэг зүйлд талархлаа илэрхийлмээр байна. Уфад болсон кино наадамд миний бие "Ээж" киноны продюссертэй хамт явсан. Гэтэл Лос-Анжелест киногоо гаргах шаардлага гарч, нэг хоногийн өмнө явах хэрэгтэй болсон юм. Тэгээд ОХУ-д суух Элчин сайдын яамныханд хандан орчуулагч гаргаж өгөхийг хүссэн. Бидний хүсэлтийг хүлээн авч, орчуулагч явуулж өгсөнд талархаж буйгаа илэрхийлмээр байна. Бидний хувьд анхны алхмаа хийлээ. Гэхдээ уран бүтээлч хувиараа бүтээлээ олон улсын наадамд сойно гэдэг тийм ч хялбархан бүтчих хэрэг биш. Тиймээс үүнийг нэгдсэн зохион байгуулалтад оруулж, жилдээ нэг уран бүтээлийг сонгон улсаа төлөөлүүлэн олон улсын тэмцээнүүдэд явуулдаг болчихвол сайн л байна.

-Жилд 30-40 кино хийгддэг гэлээ. Танай театрт бүгд гарч чадаж байна уу?

-Техникийн зарим үзүүлэлтийг хангаагүй цөөн уран бүтээлд татгалзсан хариу өгөх тохиолдол байлгүй яах вэ. Гэхдээ ихэнхийг нь гаргахыг хичээдэг. Ингэхдээ насны хязгаар тогтооно. Уг нь төрийн тусгай байгууллага үүнд хяналт тавих ёстой ч, манайд хэдэн кино театрын менежерүүд цугларч, насны ангилал тогтоон хэзээ гаргахаа шийддэг. Нэг талаар, асар том үүрэг хариуцлага бидэнд ногдож байгаа юм шиг атлаа, нөгөө талаар Монголын үзэгчдэд юу үзүүлэх, эс үзүүлэхийг ердөө тав, зургаан хүн л шийдэж байна.

-Эцэст нь асуухад, кино урлагийн салбарт зүтгэж яваа уран бүтээлчдэд та юу хэлэх вэ?

-"Ээж" кино Энэтхэгийн Колкатад болсон олон улсын кино наадамд сонгогдсон. Миний бие шүүгчээр уригдсан хэдий ч, оролцож амжсангүй. Ерөнхийдөө уран бүтээлчдэд хандаж хэлэхэд, өөрийн киногоо арилжааны, Монголын зах зээлд ханамжтай гэж бодож байвал үүгээр дуусгаж болох юм. Хэрэв тэгэж бодоогүй, киногоо дэлхий дахиныг дамнасан уран бүтээл болж чадна, үнэхээр сайн уран бүтээл болсон гэдэгт итгэлтэй байгаа бол түүнийгээ урт наслуулаарай л гэж хэлмээр байна.

Бидэнд тохиолдсон

ХҮНДХЭН ХӨГТЭЙ ЯВДЛУУД

Mika Mika Nimaka

Өнөөдөр их эвгүй юм боллоо. Найз залуугийнхаа ээжтэй танилцаад удаагүй юм. Тэгээд тэднийд байж байтал ээж нь надаар судсаа бариуллаа. /Би уламжлалтын эмч юм. /Ойр зуурын юм ярьж байтал манай хүн гал тогооныхоо өрөө рүү орсон хойгуур ээж нь "Манай хүүхдийн эрхтэн ямар байна" гээд аяархан асуув. Би юу гэж хэлэхээ мэдэхгүй бантаж, тэнэгтэж өглөө. Юу асуугаад байгаа юм бол гэж бодоод, "Гайгүй ээ" л гэлээ. Тэгсэн харин манай хүүгийн судсыг барьж үзсэн үү, бие нь ямар байна гэж асуусан байж. Түүнийг нь буруугаар ойлгож, "Барьж үзээгүй байна аа" ч гэж хариулсаныг нь яана. Өдөржин ганцаараа инээж явлаа. Жич: Хүн тэгээд шоолоод байв аа та нар.

ДУУЛГАХ СОНИН

Шүүгчдэд "гологдсон" М.Дүгэрсүрэн ШИНЭ УРАН БҮТЭЭЛ ГАРГАНА

Өнөө цагт уртын дуугаа уламжлан хойч ирээдүйдээ таниулан өвлүүлэх их үйлсэд хувь нэмрээ оруулж яваа уран бүтээлчдийн нэг бол уртын дуучин, МУСТА Д.Жавхаасайхан, Д.Үүрийнтуяа нар. Уртын дуучин хосууд урлагийн ертөнцөд монгол үндэсний язгуур урлагийг уламжлан, шинэчилж, өвлүүлэн хөгжүүлэх, зорилготой ардын уртын болон богино харилцаа дууг сэргээн дуулдаг билээ. Тэгвэл СТА Д.Жавхаасайхан өөрийн цахим хуудсаараа дамжуулан "Авьяаслаг Монголчууд" шоуны шилдэг оролцогч уртын дууч М.Дүгэрсүрэнтэй хамтарч уран бүтээл хийхээ мэдэгдлээ. Тэрбээр, "Авьяаслаг Монголчууд" шоуны шилдэг оролцогч М.Дүгэрсүрэн ахтай уулзлаа. Сэтгэл санаа өөдрөг, гүндүүгүй сайхан эр юм аа. Хамтарч уран бүтээл хийх боллоо. Тун удахгүй та бүхэндээ хүргэх болно" хэмээжээ. Тус шоуны оролцогч М.Дүгэрсүрэн шилдэг наймд шалгарсан ч эцсийн шалгаруулалтад тэнцэхгүй гэх үнэлгээг шүүгчдээс авсан билээ. Шүүгчдийн шийдвэр үзэгчдийн дургүйцлыг нэлээд хүргээд буй. Тэгвэл СТАД.Жавхаасайхан ч "Паартай байшин, паалантай суултуур дээрээс уртын дуучин тэр болгон төрөхгүй л байх шүү" хэмээн өөрийн үзэл бодлоо илэрхийлжээ.

Ямартай ч, үзэгчдийн хайр хүндэтгэлийг хүлээсэн утын дууч М.Дүгэрсүрэн шинэхэн уран бүтээлээрээ тун удахгүй уулзах бололтой. Харин тэдний уран бүтээл уртын дуу байх уу, ардын дуу байх уу гэдэг нь нууц хэвээр байна.

ЭЛСЭЛТИЙН ЗАР

"Зохиомж" дээд сургууль 2016-2017 оны хичээлийн жилд дараах мэргэжлүүдээр өдөр, орой, эчнээ, хөрвөх ангид 4 жил, 2.5 жил, 1.5 жилийн бакалаврын ангид нэмэлт элсэлт авна.

1. Телевизийн сэтгүүлч, зураглаач
2. Кино, драмын жүжигчин
3. Кино, телевизийн найруулагч
4. Бага ангийн багш
5. Сургуулийн өмнөх боловсролын багш
6. Эрх зүй
7. Санхүү, банк
8. Нягтлан бодох бүртгэл, татвар
9. Гааль, гадаад худалдаа

Жич:

- IX/1 –нээс хойш судалсан хичээлүүдийг нэмэлт цагаар нөхүүлнэ
- Өнгөрсөн хугацаанд өөр сургуульд судалсан хичээлүүдийн дүнг тооцож үргэлжлүүлэн суралцах боломж олгоно.

Сэтгүүл зүй, Урлаг судлал, Бизнесийн удирдлага ангиудад магистрын элсэлт авна.
Холбоо барих утас: 70155585, 91111187, 99608440, 80818021

СОНИРХУУЛАХАД

Доналд Трампын хөрөгтэй АЛТАН I PHONE ГАРЧЭЭ

АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулиар итгэмээргүй үр дүн гарч, улс төрийн туршлагагүй үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трамп ялалт байгуулж, тус улсын 45 дахь Ерөнхийлөгчөөр тодорсон. Тэгвэл аль хэдийнэ Трампын хөрөгтэй алтадсан "I Phone" утас гарчээ. Тус ухаалаг утсыг ОХУ-ын "Кавиар" компани үйлдвэрлэсэн байна.

"Кавиар" компани онцгой загвар бүхий алтадсан "I Phone" утсыг үйлдвэрлэдэг бөгөөд өмнө нь В.Путины хөрөгтэй утсыг хэд хэдэн удаа гаргаж байсан билээ. Үйлдвэрлэгч "Энэ утас ОХУ, АНУ-ын харилцаанд эргэлт гарахад түлхэц болно гэдэгт итгэлтэй байна. Доналд Трампын ОХУ-ын талаар хэлсэн үгс хоёр их гүрний харилцаанд эерэг өөрчлөлт авчирна" гэх тайлбарыг хийжээ. Утас 197 мянган рублийн үнэтэй гэнэ.